



2020 оны 02 дугаар сарын 05
№05 /1107/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Инновацийн тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Газрын нэгдмэл сангийн
үндсэн ангилалд хамаарах
газрын байршил, хэмжээг
тогтоох тухай**

**Монгол Улсын
олон улсын
гэрээ**

**Монгол Улс болон Олон улсын
Хөгжлийн ассоциаци хоорондын
санхүүжилтийн хэлэлцээр**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|-----|--|-----|
| 47. | Инновацийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 230 |
| 48. | Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай | 235 |
| 49. | Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай | 235 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|--|------------|-----|
| 50. | Журам батлах тухай | Дугаар 312 | 235 |
| 51. | “Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ, Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээг тогтоох журам” батлах тухай | Дугаар 316 | 241 |
| 52. | Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрын байршил, хэмжээг тогтоох тухай | Дугаар 323 | 244 |
| 53. | Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлалыг шинэчлэн батлах тухай | Дугаар 324 | 261 |

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- | | | |
|-----|---|-----|
| 54. | Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээр | 265 |
| 55. | Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-импортын банк хоорондын зээлийн хэлэлцээр | 271 |



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 12 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

ИННОВАЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Инновацийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.17, 3.1.18 дахь заалт:

“3.1.17.“инновацийн дэд бүтэц” гэж инновацийн үйл ажиллагаанд хөрөнгө, нөөцийн болон бусад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий зохион байгуулалтын бүтэц, барилга байгууламжийг;

3.1.18.“зөвлөх компани” гэж эрдэм шинжилгээний байгууллага, түүний дэргэд байгуулагдсан гарааны компанийн инновацийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх бусад этгээдэд гарааны компанийн өөрийн эзэмшлийн хувийг борлуулах зорилгоор байгуулагдсан компанийг.”

2/12¹ дүгээр зүйл:

“12¹ дүгээр зүйл.Гарааны компани хувьцаагаа олон нийтэд санал болгох

12¹.1.Гарааны компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.2-т заасан эрх бүхий байгууллагаар дамжуулан хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгож болно.

12¹.2.Гарааны компанийн олон нийтэд хувьцаа санал болгох журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

12¹.3.Гарааны компанийн олон нийтэд санал болгох нийт хувьцааны болон нэг хөрөнгө оруулагчийн худалдан авах хувьцааны үнийн дүнгийн дээд хязгаарыг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.”

3/14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.1.5 дахь заалт:

“14.1.4.энэ хуулийн 6.1.2-т заасан инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлд нийцсэн байх;

14.1.5.инновацийн төслийг энэ хуулийн 14.3-т заасны дагуу бүртгүүлсэн байх.”

4/16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг:

“16.4.Инновацийн дэд бүтэц нь шинжлэх ухааны парк, үйлдвэрлэл технологийн парк, технологи дамжуулах төв, технологийн инкубатор, бизнес-инкубатор, хамтын оффис, менежментийн компаниас бүрдэнэ. Хамтын оффис нь хоорондоо хамааралгүй хэд хэдэн хувь хүн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлсэн байх бөгөөд гишүүддээ зориулан зөвлөх, зуучлах, сурталчлах, хөрөнгө оруулалт татах, инновацийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулах зэргийг нэгдсэн журмаар зохион байгуулна:

16.4.1.технологи дамжуулах төв, эсхүл хамтын оффисд гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг төрөөс татварын бодлогоор дэмжих;

16.4.2.энэ хуулийн 16.4.1-д заасан аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батлах.”

5/17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг:

“17.3.Энэ хуулийн 17.1.1, 17.1.3, 17.1.8, 17.1.11, 17.1.12-т зааснаас бусад инновацийн үйл ажиллагааг төрөөс дэмжих хэлбэрийг өндөр технологи, инновацийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмаар зохицуулна.”

6/27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсэг:

“27.11.Зөвлөх компани нь гарааны компанийн өөрийн эзэмшлийн хувийг худалдан борлуулж болно.”

2 дугаар зүйл.Инновацийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн гарчгийн “Инновацийн”, мөн зүйлийн 13.1, 13.13, 13.14, 13.15 дахь хэсгийн



“инновацийн” гэсний дараа “үйл ажиллагааны” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “төсөлд” гэсний дараа “төрөөс” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Инновацийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт:

“3.1.1.“инновацн” гэж шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетинг, зохион байгуулалтын арга, шийдлийг;”

2/3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт:

“3.1.3.“инновацийн үйл ажиллагаа” гэж инновацийг хэрэглээнд нэвтрүүлж, эдийн засгийн үр ашиг, өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх, нийгмийн үйлчилгээг сайжруулах зорилго бүхий арга хэмжээг;”

3/3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт:

“3.1.8.“гарааны компани” гэж инновацийн бүтээгдэхүүн шинээр үйлдвэрлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан компанийг;”

4/6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт:

“6.1.2.инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг батлах;”

5/6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт:

“6.1.5.төрөөс инновацийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;”

6/10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт:

“10.1.3.төрийн захиргааны төв байгууллага харьяалах салбартаа инновацийн үйл ажиллагааг дэмжихэд шаардагдах хөрөнгийг төсөвтөө багтаан шийдвэрлэх;”

7/11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалт:

“11.1.3.орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн төслийн нээлттэй шалгаруулалт зохион байгуулах, инновацийн грант олгох;”

8/13 дугаар зүйлийн 13.6, 13.7 дахь хэсэг:

“13.6.Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөв, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн чиг хандлага зэрэгт үндэслэсэн үндэсний, салбарын, бүсийн, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

13.7.Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл таван жилийн хугацаатай байна.”

9/14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалт:

“14.1.2.хэрэгжүүлэх гэж байгаа төслийн бүтээгдэхүүн, үйлчилгээний давтагдаагүй байдал, эсхүл аж үйлдвэрийн оюуны өмчийн эрхийн баталгаажилтыг нотолсон байх;”

10/17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалт:

“17.1.6.өндөр технологи шингэсэн инновацийн бүтээгдэхүүнийг олон улсын үзэсгэлэн худалдаа, танилцуулах арга хэмжээнд оролцоход дэмжлэг үзүүлэх;”

11/27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг:

“27.2.Эрдэм шинжилгээний байгууллага дэргэдээ технологи дамжуулалт хариуцсан нэгж, гарааны компани болон гарааны компанид дэмжлэг үзүүлэх зорилго бүхий зөвлөх компанийг үүсгэн байгуулж, дараах чиглэлээр ажиллуулж болно:

27.2.1.зөвлөх компани нь инновацийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, хөрөнгө оруулагчид зуучлах гэрээг гарааны компанитай байгуулах;



27.2.2.зөвлөх компани нь энэ хуулийн 27.2.1, 27.11-д зааснаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглох;

27.2.3.гарааны компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 11-ээс доошгүй хувийг үүсгэн байгуулсан эрдэм шинжилгээний байгууллага эзэмших;

27.2.4.эрдэм шинжилгээний байгууллагын эрх бүхий этгээд нь гарааны компанийн эзэмшлийн хувиа Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу үнэлүүлсэн дүгнэлтийг үндэслэн таван жилийн дотор худалдан борлуулах.”

4 дүгээр зүйл.Инновацийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын “бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, зах зээлд нийлүүлэх” гэснийг “бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “бодлого,” гэснийг “бодлогыг батлах,” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.11 дэх заалтын “үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “үйл ажиллагаанд оролцогч талуудын” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “Стратегийн тэргүүлэх чиглэлийн” гэснийг “Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн” гэж, 14 дүгээр зүйлийн гарчгийн “Инновацийн төсөл” гэснийг “Төрөөс дэмжлэг үзүүлэх инновацийн төсөл” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “17.1.8-д” гэснийг “17.1.6, 17.1.8, 17.1.9, 17.1.10-т” гэж, 27 дугаар зүйлийн 27.10.2 дахь заалтын “шинжлэх ухааны” гэснийг “инновацийн” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Инновацийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалтын “Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангаас” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Инновацийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2, 13.3, 13.5, 13.8, 13.9, 13.10, 13.11, 13.12 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Л.ЭНХ-АМГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 12 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан Санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 12 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хоорондын зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 312

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Авто замын тухай хуулийн 24.7, Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Автобензин, дизелийн түлшний албан татварын орлогоос улсын авто замын санд төвлөрүүлэх хувь, хэмжээ”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.



2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмын дагуу улс, нийслэл, орон нутгийн авто замын санд төвлөрүүлэх, хөрөнгийг холбогдох төсөвт жил бүр тусгаж байхыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, авто замын сангийн үйл ажиллагааг нэгдсэн бодлого, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгаланд тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 149 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН САЙД**

Б.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2019 оны 312 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**АВТО ЗАМЫН САНД ХӨРӨНГӨ ТӨВЛӨРҮҮЛЭХ,
ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Авто замын тухай хуулийн 24, 25 дугаар зүйлд болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.15-д заасан улс, нийслэл, орон нутгийн авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих үйл ажиллагаанд Авто замын тухай, Төсвийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ журмыг баримтална.

1.3. Улс, нийслэл, орон нутгийн авто замын сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 27.1-д заасны дагуу Төрийн санд тус тус тусгай данстай байна.

Хоёр. Авто замын сангийн хөрөнгийн эх үүсвэр,
хөрөнгө төвлөрүүлэх

2.1. Улсын авто замын сан нь Авто замын тухай хуулийн 25.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 27.2, Автобензин, дизелийн

түлшний албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт тус тус заасан эх үүсвэрээс, нийслэл, орон нутгийн авто замын сан нь Авто замын тухай хуулийн 25.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

2.2. Авто замын сангийн тухайн жилийн төсвийг Төсвийн тухай хууль тогтоомж, түүнтэй холбогдсон журмын дагуу боловсруулна.

2.3. Улсын авто замын санд дараахь байдлаар хөрөнгө төвлөрүүлнэ:

2.3.1. импортоор оруулж ирж байгаа автомашины онцгой албан татварын 20 хувийг тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд улсын авто замын сангийн тусгай дансанд;

2.3.2. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Өрийн удирдлагын тухай хууль тогтоомжид заасны дагуу олон улс, улсын чанартай авто замын болон тусгай зориулалтын авто замын арчлалт, засвар, түүнтэй холбоотой үйл ажиллагаанд зориулж авсан зээл, буцалтгүй тусламж, хандивын хөрөнгийг тухай бүр улсын авто замын сангийн тусгай дансанд;

2.3.3. Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг тухай бүр улсын авто замын сангийн тусгай дансанд;

2.3.4. олон улс, улсын чанартай авто зам болон тусгай зориулалтын авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тухай бүр улсын авто замын сангийн тусгай дансанд;

2.3.5. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын болон гадаад улсад бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн дамжин өнгөрөх төлбөр, хураамжийг олон улсын гэрээнд заасан хувь, хэмжээгээр хагас болон бүтэн жилээр улсын авто замын сангийн тусгай дансанд;

2.3.6. аймаг, нийслэлийн Засаг дарга олон улс, улсын чанартай авто замын зурвас газарт үйлчилгээ эрхэлсний төлбөр, хураамжийг хагас болон бүтэн жилээр улсын авто замын сангийн тусгай дансанд;

2.3.7. тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд автобензин, дизелийн түлшний албан татварын орлогоос Засгийн газраас тогтоосон хувь, хэмжээгээр улсын авто замын сангийн тусгай дансанд;



2.3.8. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 27.2-т заасан улсын авто замын сангийн хөрөнгийн үлдэгдэлд тооцсон хүүгийн орлогыг Төрийн сангаас тухай бүр улсын авто замын сангийн тусгай дансанд.

2.4. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын авто замын санд төвлөрүүлэх хөрөнгийн саналыг зохих журмын дагуу боловсруулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.5. Нийслэл, орон нутгийн авто замын санд дараахь байдлаар хөрөнгө төвлөрүүлнэ:

2.5.1. автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг аймаг, дүүргийн татварын албанаас тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд;

2.5.2. орон нутгийн тухайн жилийн батлагдсан төсвөөс нийслэл, орон нутгийн авто замын санд хуваарилах хөрөнгийг тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд;

2.5.3. Өрийн удирдлагын тухай хууль тогтоомжид заасны дагуу нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засвар, түүнтэй холбоотой үйл ажиллагаанд зориулж авсан зээл, буцалтгүй тусламж, хандивын хөрөнгийг тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд;

2.5.4. нийслэл, орон нутгийн авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд;

2.5.5. аймаг, нийслэлийн Засаг дарга нийслэл, орон нутгийн авто замын зогсоол ашигласны төлбөрийн орлогыг хагас, бүтэн жилээр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд;

2.5.6. аймаг, нийслэлийн Засаг дарга авто замын зурвас газарт үйлчилгээ эрхэлсэн болон хаяг, сурталчилгаа, мэдээлэл байрлуулсны төлбөрийн орлогыг хагас, бүтэн жилээр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд.

2.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн орон нутгийн төсвөөс нийслэл, орон нутгийн авто замын санд хуваарилах хөрөнгийн хэмжээг тодорхойлон зохих журмын дагуу орон нутгийн төсөвт тусгуулна.

2.7. Нийслэл, орон нутгийн авто замын зурвас газар, зогсоол ашигласны төлбөрийн хэмжээг болон хаяг, сурталчилгаа, мэдээлэл байрлуулсны төлбөрийн хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

Гурав. Авто замын сангийн хөрөнгийг захиран зарцуулах

3.1. Тухайн жилд захиран зарцуулахаар төлөвлөсөн улс, нийслэл, орон нутгийн авто замын сангийн хөрөнгийг тухайн жилийн төсвийн тухай хуульд болон нийслэл, орон нутгийн төсөвт тус тус тусган хэрэгжүүлнэ.

3.2. Авто замын сангийн хөрөнгийг Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус зориулалтын дагуу захиран зарцуулна.

3.3. Гэнэтийн хүчин зүйл буюу байгалийн гамшигт үзэгдэл, осол болсны улмаас авто зам, замын байгууламжид эвдрэл, гэмтэл үүссэний улмаас авто замын хөдөлгөөн хэвийн үргэлжлэх боломжгүй болсон тохиолдолд сэргээн засварлахад шаардагдах зардлыг авто замын сангийн тухайн жилийн төсвөөс тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ.

3.4. Авто зам, замын байгууламжийг хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн, орчин үеийн дэвшилтэт техник технологи бүхий тоног, төхөөрөмжөөр тоноглох, шинэчлэн сайжруулахад зарцуулах зардлыг улсын авто замын сангаас санхүүжүүлнэ.

3.5. Авто замын сангийн тухайн жилийн төсвийг төлөвлөх, хуваарилахад дараахь зарчмыг баримтална:

3.5.1. төсвийн 90-ээс багагүй хувийг Авто замын тухай хуулийн 24.3, 24.4-т тус тус заасан үйл ажиллагаанд;

3.5.2. төсвийн 10 хүртэлх хувийг Авто замын тухай хуулийн 24.5-д заасан үйл ажиллагаанд.

3.6. Олон улс, улсын болон нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засвар, түүнтэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулж авсан гадаадын зээл, тусламж, хандивын хөрөнгийг Өрийн удирдлагын тухай хууль, холбогдох бусад журамд нийцүүлэн зарцуулна.

3.7. Авто замын сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.



Дөрөв. Авто замын сангийн төлөвлөлт,
хяналт, тайлан

4.1. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга улс, нийслэл, орон нутгийн авто замын сангийн хөрөнгийг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнахтай холбогдсон үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн тус тус эрхлэн явуулна.

4.2. Авто замын сангийн орлого, зарцуулалтад тавих олон нийтийн хяналтыг зам хэрэглэгчид болон иргэдийн төлөөллөөс бүрдсэн Авто замын зөвлөл хэрэгжүүлнэ.

4.3. Энэ журмын 4.1-д заасан этгээд улс, нийслэл, орон нутгийн авто замын сангийн гүйцэтгэл, зарцуулалтын тайланг улирал, жилээр тус тус гаргах бөгөөд улирлын тайланг дараа сарын 15-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор Авто замын зөвлөлд хүргүүлж тайлагнана.

Тав. Бусад

5.1. Энэ журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Засгийн газрын 2019 оны 312 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**АВТОБЕНЗИН, ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ АЛБАН
ТАТВАРЫН ОРЛОГООС УЛСЫН АВТО ЗАМЫН САНД
ТӨВЛӨРҮҮЛЭХ ХУВЬ ХЭМЖЭЭ**

№	Он	1 тн тутамд ногдох татварын орлогоос авто замын санд төвлөрүүлэх хэмжээ (төгрөг)	
		Автобензин	Дизелийн түлш
1.	2020 он	16 200	1 800
2.	2021 он	18 000	2 000
3.	2022 он	20 000	2 000
4.	Дараагийн онуудад	22 000	2 000

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 316

Улаанбаатар
хот

**“Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ,
Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх
аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт
болон хөнгөлөлтийн хувь хэмжээг
тогтоох журам” батлах тухай**

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7.1, 8.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ”-г 1 дүгээр хавсралт, “Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээ тогтоох журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цагаанхүү), Татварын ерөнхий газар (Б.Заяабал)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Н.ЦЭРЭНБАТ

Засгийн газрын 2019 оны 316 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Үзүүлэлт	Ус бохирдуулах бодисын төрөл				
	Жинлэгдэх бодис (төг/кг)	Органик бодис (төг/кг)	Эрдэс бодис (төг/кг)	Хүнд металл (төг/кг)	Аюултай бохирдуулах бодис (төг/гр)
Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ	50	50	20	500	1000



Засгийн газрын 2019 оны 316 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРӨӨС ХӨНГӨЛӨХ
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ
БОЛОН ХӨНГӨЛӨЛТИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ
ТОГТООХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь хот, суурин газрын ахуйн бохир усыг цэвэрлэдэг болон төсвөөс санхүүждэг эрүүл мэнд, боловсрол, халамжийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр ногдуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт, хөнгөлөлтийн хувь хэмжээ

2.1. Хот, суурин газрын ахуйн бохир усыг цэвэрлэдэг болон төсвөөс санхүүждэг эрүүл мэнд, боловсрол, халамжийн үйл ажиллагаа эрхэлдэг дараахь аж ахуйн нэгж, байгууллага (цаашид “аж ахуйн нэгж, байгууллага” гэх)-ын хаягдал усны чанар нь Хүрээлэн байгаа орчин, усны чанар, ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015, Хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартаар тогтоосон норм, нормативыг хангасан тохиолдолд ус бохирдуулсны төлбөрөөс дор дурдсан хувь хэмжээгээр хөнгөлнө:

№	Аж ахуйн нэгж, байгууллага	Хөнгөлөлтийн хувь хэмжээ (хувиар)
1.	Хот, суурин газрын ахуйн бохир усыг цэвэрлэдэг байгууллагууд	100
2.	Эрүүл мэндийн байгууллага: Төсвөөс санхүүждэг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв, клиник, амаржих газар, нийгмийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, сувилал, түргэн тусламжийн төв, сэргээн засах төв, тусгай эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, сувилахуйн төв	100
3.	Боловсролын байгууллага: Төсвөөс санхүүждэг ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын байгууллага, их дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехникийн коллеж, хүрээлэн, лаборатори, зохион бүтээх товчоо, туршилт-үйлдвэрлэл-үйлчилгээний бааз,	100

	шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл, улсын болон орон нутгийн музей, үндэсний номын сан	
4.	Халамжийн байгууллага: Төсвөөс санхүүждэг төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа улсын болон орон нутгийн асрамжийн газар	100

2.2. Энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны албатай хамтран улирал бүр шинэчлэн гаргаж, харьяалах Татварын албанд хүргүүлнэ.

Гурав. Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг

3.1. Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хаягдал усны сорьц авах хяналтын цэгийг тогтоох бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага бүр тогтоосон цэгт хаягдал усны сорьц авах хяналтын цэгийг “Байгаль орчин. Усны чанар. Дээжлэлт. 10-р хэсэг: Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж” MNS_ISO 5667-10:2001 стандартад нийцүүлэн байгуулна.

3.2. Хот, суурин газрын ахуйн бохир усыг цэвэрлэдэг байгууллага нь хаягдал усан дахь бохирдуулах бодисын агууламжийг Усны тухай хуулийн 25.2-т заасан байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор (цаашид “байгаль орчны итгэмжлэгдсэн лаборатори” гэх) сар бүрийн 20-ны дотор тодорхойлуулж, улирал бүрийн дүнг тухайн улирлын дараа сарын 20-ны дотор харьяалах Сав газрын захиргаанд хүргүүлнэ.

3.3. Төсвөөс санхүүждэг эрүүл мэнд, боловсрол, халамжийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага нь хаягдал усан дахь бохирдуулах бодисын агууламжийг байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор тодорхойлуулж, дүнг аймаг, нийслэлийн Байгаль орчны албанд хүргүүлнэ.

Дөрөв. Ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр ногдуулах

4.1. Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнгээр энэ журмын 2.2-т заасан хөнгөлөх жагсаалтад орсон аж ахуйн нэгж, байгууллагын хаягдал усны чанар, найрлага нь стандартаар тогтоосон норм, нормативыг хангаагүй нь тогтоогдсон тохиолдолд Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба энэ тухай мэдээллийг харьяа Татварын албанд хүргүүлнэ.

4.2. Энэ журмын 2.2-т заасан жагсаалтад хамаарах аж ахуйн нэгж, байгууллагын хаягдал усны чанар, найрлагад мэргэжлийн хяналтын байгууллага төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх бөгөөд хаягдал усны чанар, найрлага стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд энэ тухай мэдээллийг харьяалах Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны албанд мэдэгдэнэ.

4.3. Энэ журмын 4.2-т заасан шалгалтаар хаягдал усны чанар, найрлага нь стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн нь тогтоогдсон аж



ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн хяналтын байгууллага зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага өгч, тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагад Усны тухай хуулийн 25.2-т заасны дагуу улсын байцаагч ус бохирдуулсны нөхөн төлбөрийг 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр нэмэгдүүлж ногдуулна.

4.4. Татварын алба нь энэ журмын 4.3-т заасан мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн тогтоосон ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг ногдуулна.

Тав. Бусад

5.1. Ус бохирдуулсны төлбөр төлөгчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг Зөрчлийн тухай хуулиар зохицуулна.

5.2. Энэ журмын хэрэгжилтийг хангуулах үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 323

Улаанбаатар
хот

Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрын байршил, хэмжээг тогтоох тухай

Газрын тухай хуулийн 19.1.10-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын газрын байршил, хэмжээг 1 дүгээр хавсралт, газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах аймаг, нийслэлийн газрын байршил, хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрыг нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх асуудлыг тухай бүр Засгийн газраар шийдвэрлүүлж байхыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД**

Х.БАДЕЛХАН

Засгийн газрын 2019 оны 323 дугаар
 тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНДСЭН АНГИЛЛЫН БАЙШИЛ, ХЭМЖЭЭ (га)

№	Аймгийн нэр	Монгол Улсын газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал									
		Хөдөө аж ахуйн газар	Хот тосгон, бусад суурин газар	Зам, шугам сүлжээний газар	Ойн сан бүхий газар	Усны сан бүхий газар	Тусгай хэрэглээний газар				
1.	Архангай	3805671.63	27734.30	15589.90	1032903.20	22666.00	618614.70				
2.	Баян-Өлгий	2907548.29	26458.30	5787.90	20734.20	37696.10	1573497.20				
3.	Баянхонгор	8348852.67	55578.00	26042.50	363058.60	47053.60	2711717.80				
4.	Булган	2629381.31	22481.90	27658.80	1323458.30	32954.00	838509.60				
5.	Говь-Алтай	8700481.00	54402.70	14594.00	646605.00	17433.10	4738545.80				
6.	Говь-сүмбэр	479060.95	9511.60	4233.70	169.70	1027.00	59482.50				
7.	Дархан-Уул	208807.59	24379.40	6239.20	70180.30	6633.10	1374.20				
8.	Дорноговь	9357778.88	59010.80	48059.10	192743.50	25557.70	1253089.00				
9.	Дорнод	8366537.89	137185.60	37616.40	189728.70	50809.70	3565964.60				
10.	Дундговь	6867181.30	144338.70	10927.00	17634.00	16981.00	411781.00				
11.	Завхан	6454647.80	30576.30	21943.60	618589.90	62978.80	1062792.20				
12.	Орхон	35061.52	20897.10	3115.40	24323.20	1042.50	79.00				
13.	Өвөрхангай	5821695.89	27202.90	24661.10	83943.10	8354.50	320001.50				
14.	Өмнөговь	10748490.74	725412.70	204093.70	699003.10	28332.30	4103292.80				
15.	Сүхбаатар	7167577.81	19273.20	17573.10	2352.50	15041.00	1009748.20				
16.	Сэлэнгэ	2006055.22	51469.60	23018.90	1090898.50	12371.30	968013.60				
17.	Төв	5624628.51	67320.20	22706.20	580963.10	13774.60	1089948.30				
18.	Увс	4864164.71	31548.40	14000.70	137662.70	88877.40	1823293.40				
19.	Ховд	4534589.08	40876.30	21557.20	271006.20	30706.50	2702536.60				
20.	Хөвсгөл	3858745.33	27924.30	13233.00	3121238.60	67134.60	3008612.40				
21.	Хэнтий	5629415.16	48776.50	15613.40	1123764.40	18424.00	1235099.70				
22.	Нийслэл	217418.66	92911.80	6115.80	76124.40	1486.10	77476.30				
Улсын нийт дүн		108633791.94	1745270.60	584380.60	11687085.20	607334.90	33173470.40				



Засгийн газрын 2019 оны 323 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНДСЭН АНГИЛАЛД ХАМААРАХ
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ (га)**

№	Сум, дүүргийн нэр	Хөдөө аж ахуйн газар	Хот тосгон, бусад суурин газар	Зам, шугам сүлжээний газар	Ойн сан бүхий газар	Усны сан бүхий газар	Тусгай хэрэгцээний газар
1. Архангай аймаг							
1.	Батцэнгэл	306343.6	1219.0	654.6	41674.4	1036.5	
2.	Булган	133375.0	763.6	363.7	106870.2	1772.0	72973.0
3.	Жаргалант	116570.2	406.9	818.7	164100.0	997.7	0.1
4.	Их-Тамир	285880.1	1097.9	1315.8	95968.3	439.2	105620.5
5.	Өгийнуур	163731.4	636.2	554.8		3719.5	
6.	Өлзийт	162962.1	404.1	1053.3	6345.1	787.2	0.0
7.	Өндөр-Улаан	306436.2	533.2	1229.9	125381.2	974.0	
8.	Тариат	250941.6	967.3	926.2	74261.7	2660.0	76602.9
9.	Түвшрүүлэх	94735.8	5725.4	790.6	18459.7	349.4	
10.	Хайрхан	206436.9	554.5	1088.2	46172.1	1047.2	
11.	Хангай	307470.4	433.2	469.6	22686.2	2714.5	57261.1
12.	Хашаат	225828.1	650.2	1153.0		56.0	32153.8
13.	Хотонт	150650.1	743.2	974.3	46490.0	305.8	34977.3
14.	Цахир	249667.6	606.3	266.7	17791.7	1222.0	59826.5
15.	Цэнхэр	140817.3	7901.9	426.4	82593.2	955.8	89195.3
16.	Цэцэрлэг	194272.6	149.3	1217.4	55075.7	1051.1	
17.	Чулуут	244324.4	622.0	644.8	58635.9	1367.9	88024.4
18.	Эрдэнэбулган	100.6	4027.6	43.3	49.8		1978.0
19.	Эрдэнэмандал	265127.7	292.4	1598.6	70348.1	1210.2	1.8
	Аймгийн дүн	3805671.6	27734.3	15589.9	1032903.2	22666.0	618614.7

2. Баян-Өлгий аймаг

1.	Алтай	208098.7	546.2	132.5		2745.2	106071.7
2.	Алтанцөгц	169276.5	839.3	282.4	1303.6	752.5	7233.9
3.	Баянуур	158960.1	991.8	174.6	344.0	1308.1	71727.5
4.	Бугат	201159.7	0.4	773.3	1114.0	969.9	
5.	Булган	184230.3	718.6	155.2	2884.6	690.8	305052.6
6.	Буянт	181354.0	212.7	806.2		857.7	
7.	Дэлүүн	348461.7	497.6	282.3		4548.3	206093.4
8.	Ногооннуур	350790.1	4293.7	1130.5	237.9	14344.5	154958.9
9.	Сагсай	167680.7	2162.6	367.8		2033.5	147270.4
10.	Толбо	290330.5	3468.6	1017.2		3984.3	0.0
11.	Цэнгэл	259336.9	1305.4	158.7	14641.3	3581.5	366517.3
12.	Улаанхус	387676.6	2078.5	280.1	0.8	1644.7	208425.5
13.	Өлгий	321.9	9353.8	216.3	207.8	235.0	16.7
	Аймгийн дүн	2907677.7	26469.1	5777.0	20734.2	37696.1	1573368.0

3. Баянхонгор аймаг

1.	Баацагаан	715763.1	305.0	2332.3	3278.6	24814.5	0.0
2.	Баян-Овоо	316226.8	2246.6	1902.4	500.6	345.9	
3.	Баян-Өндөр	634825.2	9319.2	1991.7	211808.6	505.6	849437.4
4.	Баянбулаг	312966.1	2048.0	312.0		505.6	0.1
5.	Баянговь	350741.5	5022.8	1533.7		4.0	115736.4
6.	Баянлиг	621717.1	368.4	1757.9	18300.5	6.2	549372.1
7.	Баянхонгор	4451.7	1528.1	295.2	25.7	46.6	0.2
8.	Баянцагаан	512760.5	378.1	2026.8		167.0	949.5
9.	Бод	298039.8	169.5	1198.1	6754.9	11911.8	79410.2
10.	Бөмбөгөр	292363.8	10337.5	1081.1		409.9	
11.	Бууцагаан	519035.9	532.4	782.8		234.3	19795.0



12.	Галуут	338585.4	4304.6	1508.8	2690.8	929.2	156177.2
13.	Гурванбулаг	438878.4	1145.9	332.9		2497.9	800.3
14.	Жаргалант	296745.0	1990.6	233.3	3655.6	1021.2	113850.3
15.	Жинст	444956.9	264.8	1655.6	776.5	1018.2	69582.4
16.	Заг	244605.6	1424.8	373.4		389.2	11868.3
17.	Өлзийт	390206.0	390.3	2804.1	1077.1	510.4	7.9
18.	Хүрээмарал	401720.4	309.6	387.5		426.4	29604.0
19.	Шинэжинст	946338.6	13381.2	2304.3	103391.4	767.0	589199.7
20.	Эрдэнэцогт	251862.2	397.6	1308.9	12905.4	745.0	139312.2
	Аймгийн дүн	8332790.1	58865.1	26122.8	365165.8	47256.0	2725103.4
4. Булган аймаг							
1.	Баян-Агт	216363.4	369.5	1700.9	84182.4	3329.1	3104.3
2.	Баянуур	87801.4	669.8	861.1	407.8	1004.8	9770.0
3.	Бугат	99363.9	1087.0	1695.5	151265.1	810.6	66436.0
4.	Булган	5725.8	2133.6	348.4	686.2	18.7	7.7
5.	Бүрэгхангай	298903.9	8379.9	2485.9	38187.6	1327.5	0.1
6.	Гурванбулаг	225546.7	339.6	2444.2	1886.6	845.8	37444.3
7.	Дашинчилэн	226167.4	1447.5	1759.8	563.8	1267.7	4.3
8.	Могод	243779.9	400.5	1349.2	36459.6	1050.1	2.6
9.	Орхон	291246.0	796.6	2780.0	100404.3	4419.8	3.6
10.	Рашаант	70880.4	452.3	998.7		34.9	25967.0
11.	Сайхан	253917.1	488.9	2395.4	18187.5	1647.9	
12.	Сэлэнгэ	72022.9	880.4	1225.9	167532.5	3589.6	239508.1
13.	Төшиг	82810.6	3328.4	1296.7	297205.7	5304.9	384010.7
14.	Хангал	48177.5	473.4	1037.3	112438.7	1212.0	14.8
15.	Хишиг-Өндөр	199468.2	391.5	1957.9	40707.0	1198.0	0.0
16.	Хутаг-Өндөр	207205.2	843.1	3321.9	273343.5	5892.8	72237.3

Аймгийн дүн	2629380.2	22481.9	27658.8	1323458.3	32954.0	838510.8
5. Говь-Алтай аймаг						
1. Алтай	937224.1	3063.4	379.5	107923.3	205.9	984886.1
2. Баян-Уул	492481.4	1610.5	710.7		145.8	87800.4
3. Бигэр	345491.8	1786.5	716.0	2324.6	797.6	27617.3
4. Бугат	675200.1	16761.2	1055.9	45230.2	1058.6	263721.0
5. Дарив	294038.6	409.9	768.2	1896.4	2356.1	46949.5
6. Дэлгэр	539140.7	2935.0	1964.7		1260.9	113208.9
7. Есенбулаг	214084.8	7774.6	1248.4	3176.7		1.1
8. Жаргалан	317362.2	791.6	509.6	2085.5	473.6	40990.5
9. Тайшир	348675.5	5659.6	1847.8	255.6	3770.7	8229.4
10. Тонхил	533590.6	2458.0	376.8	6240.0	2298.3	215759.2
11. Төгрөг	317278.9	964.0	480.7	32769.6	132.4	186777.2
12. Халиун	312003.8	265.0	456.4	16331.5	20.6	183814.0
13. Хөхморьт	474990.3	311.5	260.0		853.0	156098.8
14. Цогт	595088.3	478.2	704.4	225696.9	585.9	854026.1
15. Цээл	491029.9	2261.5	746.2	23827.9	862.3	38664.3
16. Чандмань	451144.4	952.8	571.6		1286.7	355.4
17. Шарга	503060.5	750.0	1697.2	49978.2	1236.3	13115.8
18. Эрдэнэ	791624.5	5898.2	239.9	140443.0	308.0	1570838.6
Аймгийн дүн	8633510.3	55131.7	14733.8	658179.3	17652.9	4792853.7
6. Говьсүмбэр аймаг						
1. Баянтал	85574.9	1338.8	927.6	7.0	38.3	720.9
2. Сүмбэр	310878.0	2497.0	2278.2	226.6	442.4	58849.6
3. Шивээговь	82422.8	5686.6	1029.9	19.9	547.1	
Аймгийн дүн	478875.7	9522.3	4235.7	253.4	1027.8	59570.5

7. Дархан-Уул аймаг

1.	Дархан	1521.7	5975.1	847.2	34.9	384.3	134.2
2.	Орхон	37103.2	2316.4	1823.0	364.0	2167.0	12.9
3.	Хонгор	162919.2	11820.9	3438.0	69009.1	3952.1	1226.3
4.	Шарын гол	2993.5	8537.0	131.0	772.2	129.7	0.7
	Аймгийн дүн	204537.6	28649.4	6239.2	70180.3	6633.1	1374.2

8. Дорноговь аймаг

1.	Айраг	704983.4	2070.9	6063.7		3741.9	29059.1
2.	Алтанширээ	709442.6	221.3	5042.0		2209.0	0.0
3.	Даланжаргалан	352171.1	5877.8	3635.6		815.4	37925.7
4.	Дэлгэрэх	478813.7	366.8	1573.2		787.1	0.0
5.	Замын-Үүд	40355.2	2111.1	1092.9	31.8	312.6	912.0
6.	Иххэт	411205.5	933.2	2017.5		1645.4	
7.	Мандах	1102710.3	423.1	2125.3	70408.0	3511.5	86974.4
8.	Өргөн	740995.7	22982.2	5454.0		1315.4	71412.0
9.	Сайншанд	203560.8	14404.2	2203.2	8512.0	79.9	103.2
10.	Сайхандулаан	943268.7	407.4	3776.0	0.2	6633.2	0.0
11.	Улаанбадрах	1045014.9	386.2	2579.6	57470.9	1563.2	61628.9
12.	Хатанбулаг	1148795.6	423.9	3498.1	45356.4	1510.4	668351.8
13.	Хөвсгөл	763393.7	210.5	2329.2	11294.8	873.9	63119.0
14.	Эрдэнэ	692622.4	8428.5	6966.3	8.5	635.2	253098.7
	Аймгийн дүн	9337333.5	59247.2	48356.6	193082.5	25634.3	1272584.8

9. Дорнод аймаг

1.	Баян-Уул	345623.5	3182.1	4230.9	113833.3	1001.6	91793.6
2.	Баяндун	424908.7	28048.2	4295.2	37180.9	1928.4	128752.7
3.	Баянтүмэн	688944.9	2668.9	2861.6	2201.5	1570.3	142240.4
4.	Булган	694305.5	1681.9	4572.7	1185.6	3915.6	2817.0

5.	Гурванзал	282732.2	3032.1	736.2	415.4	1013.5	235547.6
6.	Дашбалбар	679226.8	8574.9	1567.8	21844.3	3888.3	162994.9
7.	Матад	2043393.5	4738.4	879.3	56.3	4519.6	258808.0
8.	Сэргэлэн	282244.0	18229.0	3728.4		2859.6	105732.5
9.	Халхгол	1226470.1	28823.3	318.9	10333.8	12602.1	1582425.9
10.	Хөлөнбуйр	224366.3	1611.0	2387.3	2971.3	1107.2	142691.1
11.	Хэрлэн	-7394.2	27446.6	601.5	12.9	503.5	
12.	Цагаан-Овоо	439313.4	3391.5	4574.4	844.0	5401.8	192861.5
13.	Чойбалсан	692719.3	4964.5	5753.4	532.9	8568.7	228825.4
14.	Чулуунхороот	360501.2	2819.9	1498.0		2668.2	274818.6
	Аймгийн дүн	8377355.2	139212.1	38005.8	191412.1	51548.6	3550309.1
10. Дундговь аймаг							
1.	Адаацаг	328602.2	1142.2	440.9		675.0	1418.0
2.	Баянжаргалан	300328.3	16156.5	336.0		1347.1	
3.	Говь-Угтаал	248039.3	5503.1	541.4	2.6	343.5	16154.4
4.	Гурвансайхан	343266.2	48518.7	496.2		718.9	153046.0
5.	Дэлгэрхангай	551110.5	8324.3	386.8		526.5	58324.1
6.	Дэлгэрцогт	247020.9	455.3	743.5		569.2	1300.4
7.	Дэрэн	359876.6	805.9	734.1		653.8	0.0
8.	Луус	313029.4	360.8	1282.8		809.7	0.0
9.	Өлзийт	1326932.8	14146.3	521.1	17631.0	2472.9	181537.7
10.	Өндөршил	456603.1	27056.2	317.7		1803.4	
11.	Сайнцагаан	328677.0	3999.2	1507.8		941.2	0.3
12.	Сайхан-Овоо	403989.9	1979.4	345.1		1977.0	0.1
13.	Хулд	598375.2	4198.7	1684.1		1395.5	0.0
14.	Цагаандэлгэр	338616.9	4925.4	690.5		1411.9	0.0
15.	Эрдэнэдалай	722709.4	6769.8	899.2		1336.2	0.0



Аймгийн дүн	6867177.6	144341.9	10927.2	17633.6	16981.7	411781.0
11. Завхан аймаг						
1. Алдархаан	560775.9	1907.0	3406.6	41460.9	4068.1	105228.5
2. Асгат	55091.7	233.4	102.5	1819.2	68.6	163651.1
3. Баянтэс	231487.6	382.8	653.5	41723.9	1921.2	0.0
4. Баянхайрхан	213288.8	318.1	645.0	45078.9	303.3	174076.5
5. Тосонцэнгэл	205751.6	3451.9	1334.9	143864.3	1185.9	7.8
6. Дөрвөлжин	705333.1	10605.9	690.2	0.0	4385.8	96431.8
7. Завханмандал	259771.4	2451.8	915.8	0.0	574.3	168281.3
8. Идэр	165021.2	582.0	791.8	34852.3	940.4	96756.8
9. Их-Уул	171067.5	439.4	830.9	108604.3	831.7	0.0
10. Нөмрөг	255509.7	439.1	1461.3	53758.2	16903.7	28973.3
11. Отгон	530540.3	381.4	725.6	649.6	3632.9	37273.0
12. Сантмаргац	200867.6	416.8	234.5	0.0	1096.1	775.7
13. Сонгино	232186.5	419.8	1067.6	9115.5	8961.4	0.0
14. Түдэвтэй	241191.3	587.0	1014.8	15597.3	9608.7	0.1
15. Тэлмэн	291593.1	426.9	1953.8	41046.8	360.8	0.7
16. Тэс	80165.6	495.9	122.4	11283.2	87.0	0.0
17. Улиастай	144.0	2542.2	5.4	0.0	2051.9	0.0
18. Урагмал	346417.7	2230.3	631.8	0.0	222.5	795.2
19. Цагаанхайрхан	239005.6	423.5	925.7	21030.36849	222.5	0.0
20. Цагаанчулуут	251317.6	298.4	1197.4	5804.0	113.1	89419.0
21. Цэцэн-Уул	142833.3	211.8	192.4	9667.9	1856.2	2.5
22. Шилүүстэй	302008.2	563.7	1136.4	255.0	931.2	101895.1
23. Эрдэнэхайрхан	308837.7	411.8	649.0	5028.1	375.0	0.0
24. Яруу	464441.2	355.1	1254.3	27949.1	1723.4	1062792.5
Аймгийн дүн	6454648.3	30576.3	21943.6	618589.1	62978.8	

12. Орхон аймаг

1.	Баян-Өндөр	1908.0	19945.2	1240.2	4299.0	352.1	79.0
2.	Жаргалант	33147.8	951.9	1875.3	20024.2	690.4	
	Аймгийн дүн	35055.8	20897.1	3115.4	24323.2	1042.5	79.0

13. Өвөрхангай аймаг

1.	Арвайхээр	2190.9	2592.1	116.5		3.5	2.9
2.	Баруунбаян-Улаан	391592.3	171.6	1325.0		1629.7	
3.	Бат-Өлзийт	34101.9	6281.7	135.6	25737.0	81.9	189824.6
4.	Баян-Өндөр	325476.7	1303.5	982.1	0.0	390.9	
5.	Баянгол	347262.4	146.1	1716.0		785.6	
6.	Богд	1002435.0	219.2	2038.5		309.9	0.0
7.	Бурд	220832.4	3719.0	1714.3		133.8	28804.2
8.	Гучин-Ус	474460.3	104.4	1264.8		339.3	0.1
9.	Есөнзүйл	218881.0	248.3	1286.2	896.3	255.6	0.0
10.	Зүүнбаян-Улаан	231879.1	336.5	1744.1	17286.8	351.3	
11.	Нарийнтгээл	264529.8	3844.8	1300.6	6.0	309.8	
12.	Өлзийт	195341.6	169.4	1162.6	34.6	407.0	0.0
13.	Сант	260307.8	226.9	1098.6		556.5	
14.	Тарагт	347476.8	334.1	2838.7		437.1	159.4
15.	Төгрөг	542689.3	408.9	813.1		856.4	0.0
16.	Уянга	260364.7	2977.0	955.8	22217.2	660.3	18528.4
17.	Хайрхандулаан	408437.9	344.0	2540.9	833.5	513.4	
18.	Хархорин	160226.8	2249.7	763.0	2532.7	193.3	64236.9
19.	Хужирт	133186.6	1549.4	846.2	14392.0	141.1	18467.8
	Аймгийн дүн	5821673.3	27226.5	24642.6	83936.0	8356.3	320024.3

14. Өмнөговь аймаг

1.	Баян-Овоо	608139.9	98990.2	3419.1		606.2	405074.3
----	-----------	----------	---------	--------	--	-------	----------

2.	Баяндалай	703010.3	2771.3	1545.1	69894.9	1106.8	287079.6
3.	Булган	565369.9	383.6	1939.4	25493.8	5044.4	146903.6
4.	Гурвантэс	1178011.2	147584.5	4577.5	259593.1	524.5	1209207.1
5.	Даланзадгад	35803.8	3508.0	986.8		150.3	3125.0
6.	Мандал-Овоо	571029.6	8071.1	1659.1	59777.7	7683.7	0.0
7.	Манлай	1194765.7	1651.5	2863.6	9961.2	2443.7	27636.8
8.	Ноён	855238.1	56250.6	922.1	49757.2	30.8	94136.5
9.	Номгон	1032818.9	24769.5	1808.1	10513.6	380.6	774175.2
10.	Сэврэй	150468.1	504.7	949.4	209.3	11.1	664941.3
11.	Ханбогд	990271.1	140362.2	7555.2	111160.5	1810.3	244914.3
12.	Ханхонгор	889632.5	22670.6	5362.2	50.0	3485.3	69226.7
13.	Хурмэн	819524.8	8239.7	161839.1	92787.3	981.5	180148.5
14.	Цогт-Овоо	567068.9	71138.1	3273.3	10753.6	2848.2	
15.	Цогтцэций	582874.2	138747.8	5401.3		1225.6	
	Аймгийн дүн	10744027.0	725643.5	204101.2	699952.0	28332.9	4106568.7
15. Сүхбаатар аймаг							
1.	Асгат	718804.1	708.1	821.9		527.0	0.0
2.	Баруун-Урт	18.1	5312.1	160.9		0.0	1.8
3.	Баяндэлгэр	687860.6	908.8	1043.4	0.7	3090.6	63128.3
4.	Дарьганга	338456.3	280.1	535.9	1604.5	950.0	142343.3
5.	Мөнххаан	672679.2	1085.3	2958.3		579.8	61883.2
6.	Наран	178322.0	685.6	416.8		1148.9	152560.2
7.	Онгон	599849.9	617.0	1668.2		1568.9	88041.5
8.	Сүхбаатар	1023299.5	3567.4	2503.1		2212.1	249255.3
9.	Түвшинширээ	430985.3	1590.9	343.8	2.0	1677.8	
10.	Түмэнцогт	193910.8	1024.6	1329.0	170.5	243.4	10537.2
11.	Уулбаян	486428.6	1237.6	2024.2		1292.3	

12.	Халзан	371467.0	639.9	1443.8		719.5	
13.	Эрдэнэцагаан	1447666.3	1796.9	2491.0	601.3	1167.6	259315.8
	Аймгийн дүн	7149747.7	19454.2	17740.3	2379.1	15178.0	1027066.6
16. Сэлэнгэ аймаг							
1.	Алтанбулаг	36129.8	905.2	517.6	53520.2	271.4	151176.1
2.	Баруунбүрэн	183154.9	554.5	1799.0	96447.7	274.6	0.2
3.	Баянгол	164999.4	6199.2	2779.9	25648.6	418.2	1.7
4.	Ерөө	150768.2	12360.9	2598.8	313980.9	1826.3	357876.6
5.	Жавхланта	105708.9	308.5	1469.7	10724.7	591.2	
6.	Зүүнбүрэн	105023.0	1356.5	637.6	9803.9	1414.5	0.6
7.	Мандал	116896.7	15778.3	2459.8	164447.9	840.1	185388.6
8.	Орхон	122758.2	1247.1	1508.6	4312.7	300.2	0.7
9.	Орхонтуул	282246.6	1844.0	2169.5	5737.5	1015.5	1.3
10.	Сайхан	122735.1	1617.8	1218.2	3494.3	760.7	13.4
11.	Сант	104763.7	374.4	789.8	29803.8	240.6	
12.	Сүхбаатар	2554.7	2065.0	181.2		44.3	92.8
13.	Түшиг	30128.3	552.5	403.5	80409.0	435.8	143254.8
14.	Хушаат	143090.0	369.2	826.1	55543.6	663.8	0.0
15.	Хүдэр	44689.1	3986.3	823.3	107304.6	332.0	110163.6
16.	Цагааннуур	254042.6	830.8	1177.8	121735.7	2433.3	68.9
17.	Шаамар	36365.5	1119.3	1658.5	7983.5	508.7	19974.7
	Аймгийн дүн	2006054.7	51469.6	23018.9	1090898.5	12371.3	968014.2
17. Төв аймаг							
1.	Алтанбулаг	525604.6	869.5	1105.8	2341.7	1982.3	34715.7
2.	Аргалант	102316.2	703.4	1178.9	1163.7	0.0	7202.1
3.	Аруст	80832.0	586.1	630.0	66.6	23.5	
4.	Батсүмбэр	73742.6	2207.3	971.5	162582.3	284.5	1110.6

5.	Баян	291973.8	1967.0	2388.9		380.2	
6.	Баяндэлгэр	168955.0	1196.2	963.4	43381.8	820.1	
7.	Баянжаргалан	285993.9	878.1	614.4	205.9	665.5	
8.	Баян-өнжүүл	476401.7	719.5	1041.3	566.2	630.4	
9.	Баянхангай	91543.8	1156.1	450.8	53.8	20.6	6970.7
10.	Баянцогт	128682.2	1225.2	537.6	16717.6	20.6	
11.	Баянцагаан	584554.4	1276.3	1086.4		961.6	
12.	Баянчандмань	43806.2	3140.6	400.6	13812.0	6.7	
13.	Борнуур	71554.4	1884.1	708.4	40405.4	141.9	
14.	Бүрэн	372623.2	1051.0	844.3		928.7	
15.	Дэлгэрхаан	215609.0	494.8	319.5		284.2	
16.	Жаргалант	142026.9	3078.3	682.9	40462.0	173.9	
17.	Заамар	253767.7	16783.3	793.4	8717.3	1447.5	
18.	Зуунмод	-29.3	1917.2	2.0		3.5	0.5
19.	Лүн	248664.6	451.6	1433.7	2558.3	953.8	49.5
20.	Мөнгөнморьт	128869.7	724.2	385.7	186920.4	410.6	353516.2
21.	Өндөрширээт	259790.0	563.9	886.1	173.2	972.4	
22.	Сэргэлэн	345591.0	18198.2	3550.8	1367.9	121.0	10785.7
23.	Сүмбэр	32635.3	609.0	78.7	1598.9	25.6	
24.	Угтаалцайдам	141523.5	1321.5	469.0	11197.0	86.2	0.1
25.	Цээл	156928.7	999.9	502.9	6367.2	387.9	
26.	Эрдэнэ	138349.2	2961.4	764.2	36046.5	79.9	634310.2
27.	Эрдэнэсант	296065.6	316.5	1145.0	375.8	234.1	11958.8
	Аймгийн дүн	5658375.8	67280.2	23936.1	577081.5	12047.1	1060620.2
18. Увс аймаг							
1.	Баруунтуруун	151335.8	728.7	329.1	16342.7	668.6	151892.0
2.	Бөхмөрөн	260819.2	4331.2	636.1	864.8	17577.2	98946.1

3.	Давст	57340.6	802.9	113.9	1543.8	406.7	470608.2
4.	Завхан	411317.5	543.4	274.0		2308.2	276533.1
5.	Зүүнговь	340612.2	307.3	168.4		6304.6	52943.7
6.	Зүүнхангай	209142.2	442.2	510.2	22748.4	1044.2	32118.1
7.	Малчин	368167.5	466.6	694.8	16603.6	6640.4	7524.8
8.	Наранбулаг	480670.1	7766.8	2308.9	13367.6	242.6	8416.8
9.	Өлгий	236016.7	492.5	817.4	0.5	868.4	0.0
10.	Өмнөговь	267472.0	690.1	1399.1	0.5	8850.0	36068.1
11.	Өндөрхангай	312522.5	456.6	827.8	1435.7	1365.8	146854.7
12.	Сагил	206789.0	360.9	1304.2	10479.1	25290.1	145709.5
13.	Тариалан	227102.7	2725.6	1509.5	3553.4	2159.1	10284.6
14.	Түргэн	150010.7	2964.4	911.7	16170.6	669.1	38929.5
15.	Төв	143692.6	635.6	101.6		5741.5	163891.5
16.	Улаангом	201377.9	3820.1	467.6	8357.4	1589.0	37262.3
17.	Ховд	240147.2	370.3	469.0	1092.3	4037.4	41983.7
18.	Хяргас	260053.5	2673.6	358.2	13017.6	710.2	46653.7
19.	Цагаанхайрхан	339586.9	969.8	799.3	7084.8	2404.2	56661.1
	Аймгийн дүн	4864176.5	31548.4	14000.7	137662.7	88877.4	1823281.7
19. Ховд аймаг							
1.	Алтай	621770.0	5530.8	3021.8	15196.0	1268.7	666631.7
2.	Булган	388315.0	5200.2	1405.3	162184.3	2623.0	251126.0
3.	Баянт	215220.6	57.6	2038.3	5.8	1923.8	148104.8
4.	Дарив	442183.4	4075.2	2186.2	1370.2	1358.5	103331.9
5.	Дөргөн	226757.0	1177.9	545.4		4842.1	180550.8
6.	Дуут	210131.4	1532.1	278.7		1870.9	907.7
7.	Жаргалант	517.9	5837.2	70.5	100.6	222.2	21.9
8.	Зэрэг	246001.4	2069.1	1337.2	262.3	2889.1	0.2

9.	Манхан	242450.0	2876.7	2540.5		1191.5	183713.7
10.	Мөнххайрхан	159686.5	1110.7	282.4	225.4	547.3	94375.3
11.	Мөст	351269.0	3441.6	1580.7	3.7	1139.8	40393.2
12.	Мянгад	242964.6	2688.6	855.1		3719.6	77319.2
13.	Үенч	327474.9	1470.9	1600.4	90854.1	974.9	317701.8
14.	Ховд	230674.6	1144.6	1244.1		1469.9	46917.8
15.	Цэцэг	163281.6	808.8	1134.3		1095.1	182127.1
16.	Чандмань	230223.1	811.2	302.1	64.1	332.4	374352.9
17.	Эрдэнэбүрэн	235680.5	1043.1	1134.2	739.7	3237.8	34947.8
	Аймгийн дүн	4534601.6	40876.3	21557.2	271006.2	30706.5	2702524.1
20. Хөвсгөл аймаг							
1.	Алаг-Эрдэнэ	200876.2	1554.3	1439.4	186458.3	2168.3	57262.2
2.	Арбулаг	309412.8	290.9	927.2	43959.2	303.9	0.0
3.	Баянзүрх	122305.4	484.6	212.6	156413.7	635.4	152140.5
4.	Бүрэнтогтох	274011.9	1579.2	878.1	85508.9	18917.2	
5.	Галт	251705.5	837.9	191.6	94246.3	1170.4	
6.	Жаргалант	167433.0	1457.3	514.3	94036.5	871.3	
7.	Их-Уул	106720.5	697.1	829.7	91519.8	1443.3	0.0
8.	Мөрөн	177.6	9467.9	342.6	1.0	180.9	
9.	Рашаант	115924.5	1261.1	569.4	77892.2	588.5	
10.	Ренчинлхүмбэ	235475.3	1260.0	319.7	242801.2	12661.6	274657.1
11.	Тариалан	154845.0	932.6	1150.3	173734.9	1138.8	8911.1
12.	Тосонцэнгэл	158910.3	566.5	1415.6	44410.8	757.7	
13.	Төмөрбулаг	174622.4	220.2	330.6	75794.1	581.0	

14.	Түнэл	224960.3	1284.6	926.7	126709.4	1770.6	
15.	Улаан-Уул	155366.8	604.0	321.7	151121.0	1423.6	697968.4
16.	Ханх	9671.9	954.5	55.6	1114.1	548.7	614643.6
17.	Цагаан-Уул	459317.1	930.4	842.7	113036.7	4644.0	
18.	Цагааннуур	13460.6	793.4	49.5	24346.6	4182.3	519075.2
19.	Цагаан-Үүр	50758.1	548.2	253.1	386995.1	3188.3	436014.4
20.	Цэцэрлэг	397627.1	778.7	536.8	229299.2	4488.1	107141.7
21.	Чандмань-Өндөр	47398.9	616.6	445.4	303542.0	1167.5	91588.0
22.	Шинэ-Идэр	151583.9	397.4	272.3	52038.6	1807.6	
23.	Эрдэнэбулган	76178.7	407.0	408.0	366259.3	2495.5	49211.6
	Аймгийн дүн	3858743.7	27924.3	13233.0	3121238.6	67134.6	3008613.9
21. Хэнтий аймаг							
1.	Батноров	479479.9	6017.8	1893.9	9482.5	1063.2	0.0
2.	Батширээт	78018.1	1579.0	348.5	373258.3	1883.9	247184.7
3.	Баян-Адрага	246432.8	823.4	563.8	45848.5	738.6	7958.3
4.	Баян-Овоо	234047.5	604.7	1265.9	4646.4	1663.3	95174.7
5.	Баянмөнх	250092.3	384.0	326.7	1348.1	2194.0	0.0
6.	Баянхутаг	598768.8	578.8	2199.1	1195.8	1189.3	0.0
7.	Биндэр	296560.2	1891.2	533.7	132238.3	1298.9	108929.4
8.	Бор-Өндөр	-1591.2	14754.3	207.3	0.0	0.0	0.1
9.	Галшар	665017.3	979.0	528.0	0.0	1585.3	0.3
10.	Дадал	87060.7	3149.4	275.6	45246.2	760.6	355019.0
11.	Дархан	426287.9	2500.5	655.3	38.2	665.0	4853.8
12.	Дэлгэрхаан	346695.1	896.6	503.1	28964.8	1221.0	4461.2

13.	Жаргалтхаан	251567.0	779.3	884.0	29867.1	426.8	0.0
14.	Мөрөн	209930.8	1591.8	945.2	833.7	807.6	8820.0
15.	Норовлин	393566.5	859.7	823.8	76314.5	419.5	77408.6
16.	Өмнөдэлгэр	477020.9	4478.8	981.7	276844.3	1669.6	330104.2
17.	Хэрлэн	368827.5	2214.8	1377.0	2859.6	466.3	0.0
18.	Цэнхэрмандал	212815.4	4869.8	1370.0	98462.4	444.8	0.0
	Аймгийн дүн	5620596.5	48952.8	15682.7	1127448.8	18497.9	1239914.4
22. Нийслэл							
1.	Баянзүрх	40951.7	15516.1	1173.9	36454.7	476.5	28091.7
2.	Баянгол		2212.2	287.3		6.6	
3.	Багануур	40618.8	17067.0	516.7	1773.8	232.4	109.3
4.	Багахангай	9098.9	5238.0	551.3		1.1	608.1
5.	Налайх	29535.9	7927.6	562.8	729.8	166.1	30203.5
6.	Хан-Уул	21070.4	13371.3	1120.2	361.9	432.2	13995.4
7.	Сүхбаатар	3865.8	4669.9	91.8	12839.5	76.0	15.5
8.	Чингэлтэй	1215.1	4279.4	66.7	3573.3	1.0	7.1
9.	Сонгинохайрхан	71060.8	22631.6	1745.2	20391.4	94.3	4445.7
	Нийслэлийн дүн	217417.3	92911.8	6115.8	76124.4	1486.1	77476.3

Тайлбар:

Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах аймаг, нийслэлийн газрын байршил, хэмжээг хавсралтад заасны дагуу аймаг, нийслэл бүрээр газрын кадастрын зураглал үйлдэж, зохих журмын дагуу улсын газрын мэдээллийн санд тусгах болон газрын нэгдмэл сангийн тооллогыг хөтлөн явуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 324

Улаанбаатар
хот

Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлалыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлал”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Аргачлал, үнэлгээ батлах тухай” Засгийн газрын 2003 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД**

Х.БАДЕЛХАН

Засгийн газрын 2019 оны 324 дүгээр
тогтоолын хавсралт

ИРГЭНД ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан гэр бүлийн хэрэгцээний болон аж ахуйн зориулалтаар Монгол Улсын иргэнд өмчлүүлэх газрын үнийг тодорхойлоход энэхүү аргачлалыг мөрдөнө.

1.2. Монгол Улсын иргэнд өмчлүүлэх газрын үнийг Газрын төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газраас тогтоосон газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээнд үндэслэн тодорхойлно.

1.3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 18.1-д заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга энэ аргачлалын дагуу иргэнд өмчлүүлэх газрын үнийг тогтооно.



1.4. Энэ аргачлалаар тодорхойлсон газрын үнэ нь иргэнд өмчлүүлэх газрын худалдах үнэ байх бөгөөд дуудлага худалдааны журмаар газар өмчлүүлэх тохиолдолд дуудлага худалдааны анхны үнэ байна.

Хоёр. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын үнийг тодорхойлох

2.1. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын үнийг байршлаас нь хамааруулан “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 3, 4, 6 дугаар хавсралтад заасан газрын суурь үнэлгээтэй адил байхаар тооцно.

2.2. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын үнийг дор дурдсан байдлаар тодорхойлно:

$$Иү = Cү * Т$$

Иү – иргэнд өмчлүүлэх газрын үнэ;

Cү – 1 м² газрын суурь үнэлгээ;

Т – талбайн хэмжээ.

Жишээ 1. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Толгойт орчимд байрлах 700 м² газрыг өмчлүүлэх тохиолдолд газрын үнийг тодорхойлох нь:

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Толгойт орчмын газар нь “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасны дагуу газрын үнэлгээний 7 дугаар зэрэглэл (бүс)-д хамаарагдаж, газрын суурь үнэлгээ нь 24 500 төгрөг байна.

Тодорхойлбол:

$$Иү = 24\ 500 \text{ төг/м}^2 * 700 \text{ м}^2 = 17\ 150\ 000 \text{ төгрөг болно.}$$

Жишээ 2. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл суманд байрлах 700 м² газрыг өмчлүүлэх тохиолдолд газрын үнийг тодорхойлох нь:

Тосонцэнгэл сумын 1 м² газрын суурь үнэлгээ нь “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтад заасны дагуу 1400 төгрөг байна.

Тодорхойлбол:

$$Иү = 1400 \text{ төг/м}^2 * 700 \text{ м}^2 = 980\,000 \text{ төгрөг болно.}$$

Гурав. Аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх газрын үнийг тодорхойлох

3.1. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.6-д заасны дагуу буюу аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх газрын үнийг байршлаас нь хамааруулан “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 3, 4, 6 дугаар хавсралтад заасан газрын суурь үнэлгээтэй адил байхаар тооцно.

Жишээ 3. Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1 дүгээр багт байрлах 1000 м² газрыг аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх тохиолдолд газрын үнийг тодорхойлох нь:

$$Иү = Сү * Т$$

Иү – иргэнд өмчлүүлэх газрын үнэ;

Сү – 1 м² газрын суурь үнэлгээ;

Т – талбайн хэмжээ.

Эрдэнэбулган сумын 1 м² газар нь “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад заасан газрын үнэлгээний 1 дүгээр зэрэглэл (бүс)-д хамаарагдах бөгөөд түүнд харгалзах газрын суурь үнэлгээ нь 5 000 төгрөг байна.

Тодорхойлбол:

$$Иү = 5\,000 \text{ төг/м}^2 * 1000 \text{ м}^2 = 5\,000\,000 \text{ төгрөг болно.}$$

3.2. Энэ журмын 3.1-д заасан зориулалтаар газрыг дуудлага худалдаагаар өмчлүүлэх тохиолдолд байршлаас нь хамааруулан газрын суурь үнэлгээний 90 хувиар газрын үнийг тооцож, газрын дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлно.

Жишээ 4. Булган аймгийн Булган сумын 1 дүгээр багт байрлах 1 000 м² газрыг аж ахуйн зориулалтаар дуудлага худалдаагаар өмчлүүлэх тохиолдолд газрын үнийг тодорхойлох нь:

$$Иү = Сү * И * Т$$



Иү – иргэнд өмчлүүлэх газрын үнэ;
Сү – 1 м² газрын суурь үнэлгээ;
И – итгэлцүүр;
Т – талбайн хэмжээ.

Булган аймгийн Булган сумын 1 дүгээр баг нь “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад заасан газрын үнэлгээний 3 дугаар зэрэглэл (бүс)-д хамаарагдах бөгөөд түүнд харгалзах газрын суурь үнэлгээ нь 8 000 төгрөг байна.

Тодорхойлбол:

$$\text{Иү} = 8\,000 \text{ төг/м}^2 * 0.9 * 1\,000 \text{ м}^2 = 7\,200\,000 \text{ төгрөг болно.}$$

3.3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.7, 5.1.8-д заасны дагуу иргэнд газар тариалангийн зориулалтаар өмчлүүлэх газрын үнийг байршлаас нь хамааруулан “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор баталсан хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог (бүс), газрын суурь үнэлгээтэй адил байхаар тооцно.

Жишээ 5. Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд газар тариалангийн зориулалтаар давуу эрхээр үнээр нь худалдаж өмчлүүлэх 3 га газрын үнийг нь тодорхойлох нь:

$$\text{Иү} = \text{Сү} * \text{Т}$$

Иү – иргэнд өмчлүүлэх газрын үнэ;
Сү – 1 га газрын суурь үнэлгээ;
Т – талбайн хэмжээ.

Цагааннуур сум нь Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасны дагуу газрын үнэлгээний Х-6 дугаар бүхий Орхон-Туулын савын бэсрэг уулсын ойт хээрийн тойрогт хамаарагдах бөгөөд 1 га тариалангийн газрын суурь үнэлгээ нь 4 970 000 төгрөг байна.

Тодорхойлбол:

$$\text{Иү} = 4\,970\,000 \text{ төг/га} * 3 \text{ га} = 14\,910\,000 \text{ төгрөг болно.}$$

3.4. Энэ журмын 3.3-т заасан газрыг дуудлага худалдаагаар өмчлүүлэх тохиолдолд байршлаас нь хамааруулан газрын суурь

үнэлгээний 90 хувиар газрын үнийг тооцож, газрын дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлно.

Жишээ 6. Төв аймгийн Баянчандмань суманд газар тариалангийн зориулалтаар дуудлага худалдаагаар өмчлүүлэх 5 га газрын дуудлага худалдааны анхны үнийг нь тодорхойлох нь:

$$Иү = Сү * И * Т$$

Иү – иргэнд өмчлүүлэх газрын үнэ;

Сү – 1 га газрын суурь үнэлгээ;

И – итгэлцүүр;

Т – талбайн хэмжээ.

Баянчандмань сум нь Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасны дагуу газрын үнэлгээний Х-7 дугаар бүхий Сэлэнгэ-Орхоны хөндийн хээрийн тойрогт хамаарагдах бөгөөд 1 га тариалангийн газрын суурь үнэлгээ 4 000 000 төгрөг байна.

Тодорхойлбол:

$$Иү = 4\,000\,000 \text{ төг/га} * 0.9 * 5 \text{ га} = 18\,000\,000 \text{ төгрөг болно.}$$

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОН

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХООРОНДЫН

САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар (цаашид “Талууд” гэх)

Найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлж, Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжихийг эрмэлздэгээ илэрхийлж,

Олон улсын худалдааны үйл ажиллагаан дахь авлигын эсрэг тэмцэх, нийгмийн болон байгаль орчны хариуцлагад тууштай байр суурь сахихын чухлыг дурдан

Дараахь зүйлийг харилцан тохиролцов:



1 дүгээр зүйл САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ДҮН, АГУУЛГА

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар нь Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх ач холбогдол бүхий Монгол Улсын Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөлд зориулан Монгол Улсын Засгийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг зөвшөөрөв.

Уг дэмжлэгийн нийт дүн болох 57,985,000 евро (тавин долоон сая есөн зуун наян таван мянган евро)-оор дээр дурдсан энэхүү Хэлэлцээрийн хавсралтад агуулгыг нь нарийвчлан тодорхойлсон төслийн гүйцэтгэлийг санхүүжүүлнэ. Үүнд:

- Франц Улсаас францын бараа, үйлчилгээ худалдан авах;
- Олгосон санхүүгийн дэмжлэгийн 30-аас хэтрэхгүй хувийг монголын болон гуравдагч орны бараа, үйлчилгээ худалдан авахад зарцуулах, холбогдох гэрээг францын гүйцэтгэгчийн хариуцлагын дор хэрэгжүүлэх.

2 дугаар зүйл ТӨСӨЛ САНХҮҮЖҮҮЛЭХ ХЭЛБЭР

Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан төслийг Бүгд Найрамдах Франц Улсын Төрийн сангийн зээлээр санхүүжүүлнэ. Төслийн хүрээнд францын талаас худалдан авах бараа, үйлчилгээг урьдчилан тохиролцсон Франц Улсын гүйцэтгэгчидтэй гэрээ шууд байгуулах аргаар бараа нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэнэ.

Монгол Улсын болон гуравдагч орны бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад Монгол Улсын хуулийн дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр худалдан авалт хийнэ.

Гэрээ тус бүрийн санхүүжилтийн эхний хэсэг нь тээвэр, даатгалыг оролцуулалгүйгээр гэрээний үнийн дүнгийн 10-20 хувь байна.

3 дугаар зүйл САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН НӨХЦӨЛ, ХЭЛБЭР

Францын Төрийн сангийн зээлийн хугацаа 30 жил бөгөөд үндсэн зээлийн төлбөрөөс эхний 10 жил чөлөөлөгдөнө. Зээлийн хүү жилийн 0.08 хувь байна. Үндсэн зээлийг хагас жил тутам ижил хэмжээтэй, дараалсан 40 удаагийн төлбөрөөр эргүүлэн төлнө. Эхний төлбөрийг тухайн зээл олгогдсон улирал дууссанаас хойш 126 сарын дараа хийнэ (төлбөрийг жил бүрийн 5 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 30-нд хийнэ). Хүүг үндсэн зээлийн үлдэгдэл дүнгээс бодох ба Францын Төрийн сангаас санхүүжилт олгосон огноо тус бүрээс эхлэн тооцож, хагас жил тутам төлнө.

Үндсэн зээл, эсхүл хүү төлөх огноо нь Францад ажлын бус өдөр таарвал, төлбөрийг дараагийн ажлын өдөр хүртэл хойшлуулна. Хугацаандаа хийгдээгүй үндсэн зээлийн болон хүүгийн төлбөрт төлбөр

хийх ёстой байсан өдрөөс эхлэн хийгдсэн өдөр хүртэл хугацаа хэтэрсний хүү тооцно. Хугацаа хэтэрсний хүүгийн хэмжээг Еврогийн овернайт дундаж индекс (EONIA), эсхүл түүнийг орлох бусад хүүн дээр 4 хувийг нэмж тооцох ба энэ нь жилийн 5 хувиас багагүй байна. Хугацаа хэтэрсний хүүг бүтэн жилээр хожимдуулбал дээрх ханшаар хүүгийн хүү тооцно.

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрыг төлөөлж Натиксис банк (банкийг төлөөлж Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны удирдлагын газар), Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам, Зээлийн гэрээг байгуулна. Уг зээлийн гэрээнд Францын Төрийн сангийн зээлийг ашиглах болон эргэн төлөх хэлбэрийг тодотгож өгнө.

4 дүгээр зүйл ТӨЛБӨР, ТООЦООНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ

Энэхүү хэлэлцээртэй холбоотой төлбөр, тооцооны мөнгөн тэмдэгт нь евро байна.

5 дугаар зүйл ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан төсөлтэй холбоотой гэрээ бүрийг байгуулахдаа дараахь нөхцөлүүдийг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- (i) Урьдчилсан байдлаар төсөлд хийсэн дүгнэлтээс гарсан зааварчилгаатай гэрээ нийцэж байх;
- (ii) Албан ёсны дэмжлэг бүхий экспортын зээлийн талаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын дүрэм, журамтай төсөл нийцэж буй эсэхийг шалгасан байх;
- (iii) Монгол Улсын Засгийн газар нь Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газартай байгуулсан өмнөх зээлүүдийн хувьд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх;
- (iv) Монгол Улсын Засгийн газарт эсхүл түүний аль нэг төрийн байгууллагад олгосон, эсхүл Монгол Улсын Засгийн газар баталгаа гаргасан этгээдэд Францын нийтийн хөрөнгө оруулалтын банк (BPIfrance)-ны экспортын даатгалын баталгаа бүхий хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл байгаа эсэхийг шалгасан байх;
- (v) Энэхүү хэлэлцээрийн 6 болон 7 дугаар зүйлд заасан үүрэг амлалтын биелэлтийн нөхцөлийг хангах;

Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан төсөлтэй холбоотой гэрээ тус бүр дээрх нөхцөлүүдийг бүрэн гүйцэд хангаж байна гэж францын эрх бүхий байгууллага үзвэл, түүний зөвшөөрлийг үндэслэн Монгол дахь Францын Элчин сайдын яамны Эдийн засгийн албаны дарга Монгол Улсын Сангийн яамтай захидал солилцсоноор уг гэрээ энэхүү хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж эхлэх үндэс бүрдэнэ.



6 дугаар зүйл АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ТАЛААР ХҮЛЭЭХ ҮҮРЭГ АМЛАЛТ

Талууд энэхүү хэлэлцээрийн оршилд олон улсын худалдааны үйл ажиллагаан дахь авлигын эсрэг тэмцлийг дэмждэгээ илэрхийлсэн. Уг хэлэлцээрийн хүрээнд гэрээ байгуулах талууд нь өөрсдийн болон өөр нэг талын ашиг сонирхлын тулд гуравдагч этгээдэд шууд болон шууд бус замаар хууль бус үйл ажиллагаа, авлига авах нөхцөлийг бүрдүүлж болохуйц шударга бус, мөнгөтэй холбоотой, эсхүл бусад давуу талыг санал болгох, олгох, амлах, мөн түүнтэй адилтгах зүйлийг тэднээс шаардаж болохгүй.

Талууд уг төслийн хүрээнд авлигын аливаа үйлдэл бий болгохгүй байх үүрэгтэй. Талууд нь сэжиг бүхий нөхцөл байдлын талаар мэдмэгцээ харилцан мэдээлэх, нөхцөл байдлыг арилгахын тулд шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын сэтгэл ханамжид нийцүүлэх үүрэг хүлээнэ.

Дээр дурдсан үүргийг биелүүлээгүй тохиолдолд Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар нь өөрийн зүгээс хамгийн зохимжтой гэж үзэх гэрээ байгуулахаас татгалзах, эсхүл Монгол Улсын Засгийн газарт олгохоор тохиролцсон санхүүгийн тусламжийн төлбөрийг түдгэлзүүлэх, эсхүл Монгол Улсын Засгийн газарт олгосон санхүүжилтийг нийтэд нь, эсхүл хэсгийг нь тохирсон хугацаанаас эрт төлөхийг шаардах эрхтэй.

7 дугаар зүйл НИЙГМИЙН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАРИУЦЛАГЫН ТАЛААР ХҮЛЭЭХ ҮҮРЭГ АМЛАЛТ

Тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор Талууд нь Олон улсын хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрсөн байгаль орчны болон нийгмийн хэм хэмжээ, үүний дотор Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ), Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйл мөн хүрээлэн буй орчны талаарх олон улсын конвенцуудыг, тухайлбал удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцыг дагаж мөрдөхийг хөхиүлэн дэмжих шаардлагатайг санал нэгтэй зөвшөөрөв.

8 дугаар зүйл САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ХУГАЦАА

Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан санхүүгийн дэмжлэгийг авахын тулд, францын гүйцэтгэгч болон монголын захиалагчийн хооронд гарын үсэг зурсан гэрээний эрх 2020 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор нээгдсэн байна.

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд олгож буй Францын Төрийн Сангийн зээлийн хөрөнгийг 2024 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор ашиглаж дууссан байна.

Шаардлагатай тохиолдолд, эдгээр хугацааг Талууд хоорондоо тохиролцож, захидал солилцох хэлбэрээр сунгаж болно.

9 дүгээр зүйл ТАТВАР, ХУРААМЖ

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд олгож буй санхүүжилтийг Монгол Улсад ямар нэгэн татвар, хураамж төлөхөд ашиглахгүй.

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд 1996 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан “Давхар татвараас харилцан чөлөөлөх тухай хэлэлцээр”-т өөрөөр заасан байсан ч, уг хэлэлцээрийн хүрээнд төлөвлөсөн санхүүжилтийг Монгол Улсын хөгжилд бүрэн ашиглах үүднээс хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан төслийн хэрэгжилт, уг төсөлд олгосон санхүүгийн дэмжлэгийг эргүүлэн төлөхтэй холбоотой бүхий л үйл ажиллагаа энэхүү хэлэлцээрийг Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсны дараа Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ногдуулах албан татвар, хураамж (онцгой албан татвар, гаалийн татвар болон НӨАТ)-аас чөлөөлөгдөнө.

Хэрэв Монгол Улсад мөрдөгддөг дүрэм, журмын дагуу агуулга, зориулалтаас үл хамааран зайлшгүй татвар, хураамж төлөхөөр болсон тохиолдолд түүнийг францын тал, эсхүл францын компаниуд хариуцахгүй.

10 дугаар зүйл ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар өөрийн зардлаар энэхүү хэлэлцээрт тусгасан төслийн Монгол Улсын эдийн засгийн хөгжилд үзүүлсэн үр нөлөөг эдийн засаг, санхүү болон нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтүүдээр гарган дүгнэж болно. Монгол Улсын Засгийн газар энэхүү судалгаанд оролцох, судалгааны үр дүнг шууд хүртэх боломжтой.

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраас томилсон дээрх судалгаа, дүгнэлт хийх шинжээчдийг Монгол Улсын Засгийн газар хүлээн авах, тэднийг шаардлагатай мэдээллээр хангах үүргийг хүлээнэ.

11 дүгээр зүйл ХЭЛЭЛЦЭЭР ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

Энэхүү хэлэлцээр нь Талууд түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа харилцан мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.



12 дугаар зүйл ХЭЛЭЛЦЭЭРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

Энэхүү хэлэлцээрт Талуудын бичгээр тохиролцсоныг үндэслэн нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

13 дугаар зүйл МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотой үүдэн гарах аливаа маргааныг Талууд харилцан зөвлөлдөх, хэлэлцэх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

Дээр дурдсаныг хүлээн зөвшөөрч хоёр улсын Засгийн газрын эрх бүхий төлөөлөгчид энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

Улаанбаатар хот 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдөр монгол, франц хэлээр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

ЧИМЭДИЙН ХҮРЭЛБААТАР
Сангийн сайд

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

ФИЛИПП МЭРЛИН
Бүгд Найрамдах Франц Улсаас Монгол
Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт
Элчин сайд

ХАВСРАЛТ

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд олгож буй 57,985,000 евро (тавин долоон сая есөн зуун наян таван мянган евро)-гийн санхүүгийн дэмжлэг нь Монгол Улсын Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төслийг таатай нөхцөлөөр санхүүжүүлэх зорилготой.

Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан төслийн бүрэлдэхүүн хэсгийг дараахь байдлаар тодорхойлно. Үүнд:

- Гал унтраах, аврах ажиллагааны 42 автомашин нийлүүлэх ба дүн нь 14,985,000 евро (арван дөрвөн сая есөн зуун наян таван мянган евро);

- Ашиглаж байсан 3 нисдэг тэрэг, онцгой байдлын ажиллагааны холбогдох тоног төхөөрөмж, нисгэгч, механикчдын сургалт, үүнтэй холбогдох тоног төхөөрөмжүүд (1 шинэ Кабри нисдэг тэрэг, нислэгийн 1 симулятор)-ийг нийлүүлэх болон сургалт явуулах, нисэх үйл ажиллагаа гүйцэтгэхэд шаардлагатай дэд бүтцийг барих ба дүн нь 43,000,000 евро (дөчин гурван сая евро);

Энэхүү хавсралт нь Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан Санхүүгийн хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОН

БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛСЫН
ЭКСПОРТ-ИМПОРТЫН БАНК

ХООРОНДЫН

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

2019 оны 10 дугаар сарын 9-ний өдөр

ЭНЭХҮҮ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ Нэг талаас Монгол Улсын Засгийн газар түүнийг төлөөлж Сангийн сайд Ч.Хүрэлбаатар (цаашид “Зээлдэгч” гэх ба хэрэв тухайн агуулгад өөрөөр заагаагүй бол түүний залгамжлагч буюу эрх, үүргийг шилжүүлэн авах эрх бүхий этгээдийг үүнд мөн хамааруулж ойлгоно), нөгөө талаас 1981 оны Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын Банкны тухай хууль (Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Парламентаар баталсан)-иар байгуулагдсан, Энэтхэг Улсын Мумбай хотын 400 005, Куфе Парад дахь Дэлхийн худалдааны төв цогцолборын 1-р Төв байрны 21 давхарт төв нь байрлах Бүгд Найрамдах Энэтхэг Улсын ЭКСПОРТ-ИМПОРТЫН БАНК (цаашид «ЭКСИМ банк” гэх ба хэрэв тухайн агуулгад өөрөөр заагаагүй бол түүний залгамжлагч буюу эрх, үүргийг шилжүүлэн авах эрх бүхий этгээдийг үүнд мөн хамааруулж ойлгоно) хооронд 2019 оны 10 дугаар сарын 9-ний өдөр байгуулав.

ХЭЛЭЛЦЭЭРЭЭР:

(i) Талууд Зээлдэгч болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хооронд Зээлдэгчийн улсад “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийг санхүүжүүлэх зорилгоор ЭКСИМ банкнаас нийт 236 сая ам.доллар (Хоёр зуун гучин зургаан сая ам.доллар)-ын зээлийг Зээлдэгчид олгохоор харилцан тохиролцов.

(ii) Талууд зээлийн нөхцөлүүдийг тодорхойлохыг эрмэлзэв.

ИЙМЭЭС, Зээлдэгч болон ЭКСИМ банк дараахь асуудлаар харилцан тохиролцов. Үүнд:



1. Тодорхойлолт:

Энэхүү Хэлэлцээр болон Хуваарьт дурдсан дараахь нэр томьёо нь тухайн агуулгад өөрөөр заагаагүй бол дор дурдсан утгыг илэрхийлнэ. Үүнд:

“Урьдчилгаа” гэж энэхүү Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд заасны дагуу гаргах Зээлийн зарцуулалт бүрийг, эсхүл тухайн агуулгаас хамааран үндсэн зээлийн төлөгдөөгүй дүнг;

“Зээлдэгчийн улс” гэж Монгол Улсыг;

“Ажлын өдөр” гэж Хэлэлцээрт заасан зорилгын дагуу Мумбай, Улаанбаатар, Нью Йорк болон Лондон хот дахь ЭКСИМ банкны үйл ажиллагаа явуулах аливаа өдрийг;

“Худалдан авагч” гэж Зээлдэгчийн улсад байгаа, эрх бүхий гэрээний худалдан авагчийг;

“Зээл” гэж энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан зээлийг бүхэлд нь, эсхүл түүний аливаа хэсгийг болон мөн тухайн агуулгаас хамаарч тухайн үеийн үндсэн зээлийн төлөгдөөгүй дүнг;

“Төслийн нарийвчилсан тайлан” буюу “ТНТ” гэж Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас баталсан журмын дагуу бэлтгэсэн, Зээл олгох эрх олгоход ашиглах нарийвчилсан тайланг;

“Доллар” болон “ам.доллар”, “\$” тэмдэглэгээ нь Америкийн Нэгдсэн Улсын хууль ёсны мөнгөн тэмдэгтийг;

“Эрх бүхий гэрээ” гэж энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасны дагуу зээлийн хөрөнгөөс санхүүжих эрх бүхий гэрээг;

“Эрх бүхий бараа, үйлчилгээ” гэж ЭКСИМ Банкнаас энэхүү Хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэхийг зөвшөөрсөн, бараа, ажил, үйлчилгээний үнийн дүнгийн 75-аас доошгүй хувийг Энэтхэг Улсын Худалдагч ханган нийлүүлэх (Энэтхэг Улсын Засгийн газрын шийдвэрээр 10%-иар бууруулж болно) бөгөөд үлдсэн 25% (10% бууруулсан тохиолдолд 35%) болох бараа, үйлчилгээг Худалдагч эрх бүхий гэрээний зорилгоор Энэтхэгээс бусад улсаас худалдан авч нийлүүлж болох эрх бүхий гэрээний дагуу Зээлдэгч улсад хэрэгжүүлэх төсөлд зориулагдсан зөвлөх үйлчилгээ зэрэг аливаа бараа, ажил, үйлчилгээг;

“Эрх бүхий үнэ” гэж эрх бүхий гэрээний дагуу FOB (хөлгийн тавцан хүртэл төлөгдсөн)/CFR (өртөг, зардал, тээвэр)/CIF (өртөг, зардал, даатгал, тээвэр)/CIP (тээврийн хөлс, даатгал төлөгдсөн) нөхцөлөөр 100% (нэг зуун

хувь) хүртэл төлөх, ЭКСИМ банкнаас зээлийн эх үүсвэрээс Зээлдэгчид олгох гэрээний дүнг;

“Зөрчилд тооцогдох тохиолдол” гэж Ерөнхий нөхцөлийн К.1 хэсэгт заасан аливаа тохиолдлыг, эсхүл мэдэгдэл өгснөөр, хугацаа өнгөрснөөр болон/эсхүл бусад шаардлагыг биелүүлснээр дээрх хэсэгт дурдсан тохиолдолд тооцогдох нөхцөлийг;

“FOB/CFR/CIF/CIP” гэж Инкотермс 2010-д тодорхойлсон далайн тээврийн нөхцөлүүдийг;

“Ерөнхий нөхцөл” гэж энэхүү Хэлэлцээрийн хавсралт Хуваарьт заасан, хэлэлцээрийн салшгүй хэсэг болох нөхцөл, болзол, дүрэм, журам болон бусад заалтыг хэлэх бөгөөд тэдгээрийг энд ишлэн оруулсанд тооцно;

“Хүү төлөх өдөр” гэж Хэлэлцээрийн хүрээнд эхний гэрээг баталсны дараагаар ЭКСИМ банкнаас заасан, Зээлдэгч Хэлэлцээрийн дагуу хүү болон бусад төлбөрийг төлбөл зохих хуанлийн жилийн хоёр өдрийг;

“Хүү төлөх хугацаа” гэж тухайн тохиолдлоос хамааран Урьдчилгаа, эсхүл Зээлтэй холбогдуулан Ерөнхий нөхцөлийн С хэсэгт заасан хугацааг;

“Хүүгийн хэмжээ” гэж тухайн тохиолдлоос хамааран Урьдчилгаа, эсхүл Зээлийн төлөгдөөгүй дүнд ЭКСИМ банкнаас ногдуулах жилийн нэг зууны далан таван хувийн (1.75%) хүүг;

“Гүйлгээ хийх банк” гэж энэхүү Хэлэлцээрийн 3.1(d) заалтад заасан аккредитив нээх эрх бүхий банкиг;

“Хэлэлцээ хийх банк” гэж ЭКСИМ банкиг хэлнэ. Худалдагч аккредитивын хүрээнд хийх хэлэлцээний баримт бичгийг ЭКСИМ банкинд хүргүүлэх ба ЭКСИМ банк нь Худалдагчид эрх бүхий гэрээний төлбөрийг шилжүүлнэ;

“Төлбөрийн зөвшөөрөл” гэж 4 дүгээр зүйлд заасны дагуу Зээлдэгчээс ЭКСИМ банкинд эрх бүхий гэрээний төлбөрийг Худалдагчийн дансанд шилжүүлэх эрхийг олгосон зөвшөөрлийг;

“Төсөл” гэж ЭКСИМ банкнаас зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхийг зөвшөөрсөн төсөл, түүнд хамааралтай бараа, үйлчилгээг хэлэх ба Зээлдэгч болон ЭКСИМ банк харилцан тохиролцож үүнд өөрчлөлт оруулж болно;

“Төслийн менежментийн зөвлөх/ Зөвлөх (ТМЗ)” гэж Төслийн нарийвчилсан тайлан (ТНТ)-г боловсруулах, бараа худалдан авах,



Зээлдэгч улсын хэрэгцээ, шаардлагаас хамаарч төслийн менежмент болон Төслийн хүрээнд авах бусад зөвлөх үйлчилгээг үзүүлэх Зээлдэгчээс томилсон Энэтхэг зөвлөхийг;

“Эргэн төлөх өдөр” гэж Зээлийн хэсэг бүрийг эргэн төлөх өдрийг;

“Худалдагч” гэж эрх бүхий гэрээний дагуу Энэтхэг Улсын худалдагчийг хэлэх бөгөөд үүнд зөвлөх/ТМЗ-г мөн хамааруулна;

“Тээвэрлэлт” гэж Худалдагч болон Худалдан авагч харилцан тохиролцсон далайн, эсхүл бусад төрлийн тээвэрлэлтийг;

“Зарцуулалтын сүүлийн өдөр” гэж Төслийн үйл ажиллагаа төлөвлөсний дагуу дуусгавар болсон өдрөөс хойш 60 (жаран) сарын хугацаа дууссаны дараахь өдрийг хэлнэ.

2.Зээлийн дүн:

ЭКСИМ банк нь 236 сая ам.доллар (хоёр зуун гучин зургаан сая ам.доллар)-ын зээлийг Зээлдэгчид олгохоор зөвшөөрч, Зээлдэгч нь энэхүү зээлийг эрх бүхий гэрээ бүрийн дагуу эрх бүхий барааг эрх бүхий үнээр энэхүү Хэлэлцээрт заасан нөхцөл, журмын дагуу худалдан авахад ашиглахаар тохиролцов.

3.Зээлээр санхүүжүүлэх эрх бүхий гэрээ:

3.1.Гэрээ дараахь нөхцөлийг хангаагүй бол Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй. Үүнд:

- (a) Гэрээг Зээлдэгчийн улсад эрх бүхий бараа, үйлчилгээг импортлох зорилгоор байгуулсан ба зөвлөх үйлчилгээ бүхий гэрээний хувьд зөвлөх үйлчилгээг Энэтхэг Улсаас авахаар заасан байх;
- (b) Гэрээний үнийн дүнг ам.доллараар илэрхийлэх ба 50,000 ам.доллар (тавин мянган ам.доллар)-оос багагүй байх буюу эсхүл тухай бүр ЭКСИМ банк болон Зээлдэгч хооронд тохиролцсон дүн байх;
- (c) Зээлдэгч нь гэрээг гүйцэтгэх Худалдагчийг сонгон шалгаруулахдаа Хавсралт I-д заасан Худалдан авах ажиллагааны журмын дагуу тендер шалгаруулалтыг ил тод, шударга явуулна. Зээлдэгч тендер шалгаруулалтыг нээлттэй, шударга явуулах үүднээс барааны техникийн тодорхойлолт/ эрх бүхий байх шалгуурын үндсэн дээр Энэтхэг Улсын нийлүүлэгчдийг сонгон шалгаруулахдаа ЭКСИМ

банктай зөвшилцөж явуулахаа баталгаажуулав. Зээлдэгч түүнчлэн Худалдагчийг өрсөлдөөнт нээлттэй сонгон шалгаруулалт явуулж сонгосон тухай нотолгоог сонгон шалгаруулалтын журам, ирүүлсэн үнийн санал, харьцуулсан үнэлгээ болон бусад холбогдох шалгуур үзүүлэлтийн талаарх дэлгэрэнгүй тайлбарын хамт ЭКСИМ банкинд хүргүүлнэ;

- (d) Гэрээнд Худалдан авагч Худалдагчийн аккредитивын дагуу үйлчилгээнээс бусад эрх бүхий барааны үнийн дүнг ачигдсан тоо хэмжээний дагуу FOB/CFR/CIF/CIP нөхцөлөөр 100% (зуун хувь) төлөхөөр заасан байх;
- (e) Зээлдэгч нь энэхүү хэлэлцээрээр Эрх бүхий бараа, үйлчилгээг Зээлдэгчийн улсын бүх төрлийн татвар, хураамжаас чөлөөлөх тухай нотолгоог ЭКСИМ банкинд гаргав;
- (f) Худалдагч нь ЭКСИМ Банкнаас Эрх бүхий бараа, үйлчилгээний нэхэмжлэлийн дүнгийн Эрх бүхий үнийн зохих хэсгийг эсвэл урьдчилгаа төлбөрийг нэхэмжлэх боломжийг олгох үүднээс Худалдан авагч нь Зээлдэгчийн зүгээс ЭКСИМ Банкнд төлбөрийн зөвшөөрөл үйлдэхийг шаардах нөхцөлийг гэрээ нь бүрдүүлнэ;
- (g) Гэрээнд Эрх бүхий бараа болон үйлчилгээг ачуулахаас өмнө Худалдан авагчийн нэрийн өмнөөс барааг шалгах, мөн Худалдагч энэхүү Хэлэлцээрийн (d) дэд хэсэгт заасан аккредитивын зохицуулалтын дагуу барааны баримт бичгүүдийг бүрдүүлэхдээ бараа шалгасан гэрчилгээг Хэлэлцээ хийх банкинд мөн хүргүүлэх тухай заах;
- (h) Түүнчлэн, гэрээнд энэхүү Хэлэлцээрийн дагуу зээлийн ашиглаагүй аливаа хэсгийг түдгэлзүүлсэн, эсхүл цуцалсны улмаас эрх бүхий барааг, эсхүл түүний хэсгийг санхүүжүүлэх боломжгүй болсон тохиолдолд ЭКСИМ банк Худалдан авагч, эсхүл Худалдагчийн өмнө хариуцлага хүлээхгүй тухай заах;
- (i) Зээлдэгч нь Хавсралт II-т заасан хэлбэрээр гэрээний талаарх товч мэдээлэл, ЭКСИМ банкнаас шаардаж болох бусад баримт бичиг, мэдээллийг ЭКСИМ банкинд хүргүүлсэн ба ЭКСИМ банк нь гэрээг Зээлд хамруулсныг баталж, эрх бүхий үнийг тодорхой заасан зөвшөөрлийг бичгээр олгосон болно;
- (j) гэрээнд төслийг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгасан байна;
- (k) гэрээг энэхүү Хэлэлцээр байгуулагдсанаас хойш 18 сарын дотор байгуулсан байна;
- (l) ЭКСИМ Банк нь II хавсралт баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг Зээлдэгчээс хүлээн авна.



3.2 Эрх бүхий гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулахаар талууд тохиролцсон бол Зээлдэгч нь ЭКСИМ банкинд оруулсан өөрчлөлтийн тухай дэлгэрэнгүй тайлбарыг тэдгээр өөрчлөлтийг Зээлдэгч зөвшөөрч баталсан тухай нотолгооны хамт хүргүүлнэ. Гэхдээ, хэрэв оруулж буй өөрчлөлт нь гэрээний цар хүрээ, агуулгад материаллаг өөрчлөлт оруулахгүй буюу гагцхүү гэрээний дагуу нийлүүлэх Эрх бүхий бараа, үйлчилгээний техникийн үзүүлэлтийг өөрчлөх төдий байвал ЭКСИМ банк нь зөвшөөрөл олгох шаардлагагүй. Тийм боловч аливаа өөрчлөлт оруулах тохиолдолд Зээлдэгч нь ЭКСИМ банкинд тэр тухай мэдэгдэнэ.

4. Зээлийн зарцуулалт

4.A Аккредитиваар худалдан авах эрх бүхий бараа, үйлчилгээ:

4.A.1 Гэрээний 3.1(d) заалттай уялдуулан ЭКСИМ банк холбогдох гэрээг Зээлийн хүрээнд багтаасны дараа Гүйлгээ хийх банк зарцуулалтын сүүлчийн өдрөөс өмнө ЭКСИМ банктай зөвшилцөн бүх аккредитивын дансыг товлосон хугацааны дотор нээнэ. Аккредитивыг нээхдээ Хэлэлцээ хийх банктай зөвшилцөнө. Аккредитивыг Олон улсын худалдааны танхимаас гаргасан (Хэвлэл No.600) Баримтын аккредитивын нийтлэг журам, хэм хэмжээ (2007 онд шинэчилсэн)-ний дагуу нээх ба энэ нь буцаан үл дуудах аккредитив байна. Аккредитив тус бүр гэрээний үнийн дүнг хамрах ба аккредитивд тодорхойлсон баримт бичиг, ТМЗ/Худалдан авагчийн үйлдсэн Энэтхэг Улсаас худалдан авах хувь хэмжээний шаардлагыг хангаж байгаа тухай баталгаа болон төлбөрийн зөвшөөрлийг бүрдүүлж өгсөнөөр төлбөрийг Худалдагчид шилжүүлнэ.

4.A.2 Худалдагчийн Хэлэлцээ хийх банкинд өгсөн баримт нь бүрэн бөгөөд холбогдох аккредитивт нийцэж буй бол Хэлэлцээ хийх банк Худалдагчид төлбөрийг шилжүүлнэ. Төлбөрийн үнийн дүн нь холбогдох урьдчилгаа болон барьцаа төлбөрийг хасаж тооцсон Эрх бүхий гэрээний үнийн дүнгийн холбогдох нэхэмжлэлд ногдох хэсгийн зуун хувиас (100%) илүүгүй байх ба Хэлэлцээ хийх банкны арилжааны ханшаар тооцсон адил хэмжээний үнийн дүнг Худалдагчийн дансанд Хэлэлцээ хийх банк шилжүүлнэ.

4.A.3 ЭКСИМ банк 4.A.2 заалтад дурдсанаар Хэлэлцээ хийх банк болохын хувьд шилжүүлсэн дүн нь ЭКСИМ банкнаас Зээлдэгчид олгох Зээлийн урьдчилгаанд тооцогдох бөгөөд ЭКСИМ банк Мумбайгаас Худалдагчид шилжүүлэг хийсэн өдрийг Урьдчилгаа хийсэн өдөр гэнэ. ЭКСИМ банк Урьдчилгааны дүн болон өдрийг Зээлдэгчид мэдэгдэнэ. Зарцуулалт болон дансны гүйлгээтэй холбоотой ЭКСИМ банкны тайлан тооцоо эцсийн, илэрхий алдаагүй байх бөгөөд Зээлдэгчийн хувьд заавал мөрдөгдөх шинжтэй байна.

4.А.4 Зээлдэгчийн улсын гадна төлөгдөх банкны хураамж, зардал, шимтгэл, эсхүл тэмдэгтийн хураамжийг Худалдагч хариуцах бөгөөд Зээлдэгчийн улсын дотор төлөгдөх төлбөрийг Худалдан авагч хариуцна.

4.А.5 ЭКСИМ банк ямар ч нөхцөлд аккредитивыг ашиглах, эсхүл холбогдох баримт бичгийг шилжүүлэхтэй холбоотойгоор хийгдэх үйлдэл, эс үйлдэлд хариуцлага хүлээхгүй.

4.В Төлбөрийн зөвшөөрлийн дагуу зарцуулалт хийх:

4.В.1 Зээлдэгч нь:

- (i) Эрх бүхий гэрээний дагуу урьдчилгаа төлбөр (урьдчилгаа төлбөрийг Зээлийн хөрөнгөөс санхүүжүүлэхээр тохиролцсон бол) хийх бол Худалдагчид урьдчилгаа төлбөрийг шилжүүлэх тухай Худалдан авагчийн хүсэлтийг хүлээн авснаар,
- (ii) Эрх бүхий гэрээний дагуу Зээлдэгч улсад Худалдагчийн гүйцэтгэсэн ханган нийлүүлэлт, ажил эсвэл үзүүлсэн үйлчилгээний дүнг илэрхийлсэн ТМЗ болон Худалдан авагчийн зохих журмын дагуу баталгаажуулсан, Энэтхэг Улсаас авах худалдан авалтын хувь хэмжээний шаардлагыг хангаж байгааг баталгаажуулсан Худалдагчаас ирүүлсэн нэхэмжлэлийг авснаар, эсхүл
- (iii) Эрх бүхий гэрээний дагуу барьцааны мөнгийг чөлөөлөх тухай Худалдагчийн Худалдан авагчид гаргах хүсэлтийг авснаар

холбогдох нэхэмжлэх буюу хүсэлтэд үндэслэн эрх бүхий үнийн дүнг Худалдагчид шилжүүлэх Төлбөрийн зөвшөөрлийг Хавсралт III-т заасан маягтын дагуу гаргаж ЭКСИМ банкинд хүргүүлнэ.

4.В.2 ЭКСИМ банк Зээлдэгчийн Төлбөрийн зөвшөөрлийг эх хувиар хүлээн авснаар заасан үнийн дүнг Худалдагчийн ЭКСИМ банкинд урьдчилан мэдэгдсэн банкин дахь дансанд шилжүүлнэ.

4.В.3 Төлбөрийн зөвшөөрлийн дагуу дээр дурдсан Худалдагчийн дансанд ЭКСИМ банкны хийсэн шилжүүлэг нь ЭКСИМ банкнаас Зээлдэгчид өгөх Зээлийн урьдчилгаа болох ба ЭКСИМ банк Мумбайгаас Худалдагчийн дансанд уг төлбөрийг шилжүүлсэн буюу төлсөн өдрийг Урьдчилгаа хийсэн өдөр гэж үзнэ. ЭКСИМ банк Зээлдэгчид Урьдчилгаа хийсэн өдөр болон дүнг мэдэгдэнэ. Зээлдэгчийн данснаас хийгдсэн зарцуулалттай холбоотой ЭКСИМ банкны тайлан тооцоо эцсийн, илэрхий алдаагүй байх бөгөөд Зээлдэгчийн хувьд заавал мөрдөгдөх шинжтэй байна.

4.С Дээр дурдсанаас үл хамааран, зарцуулалтын сүүлчийн өдрөөс хойш Худалдагчид ямар нэг төлбөр хийх, эсхүл Зээлийн нийт дүнгээс



хэтэрсэн дүнг төлөх үүргийг ЭКСИМ банк хүлээхгүй. Иймээс, Зээлдэгч эрх бүхий гэрээг байгуулахдаа 4.А.1 заалтад заасан хугацаанд аккредитивыг нээх, эсхүл тухайн тохиолдолд Төлбөрийн зөвшөөрлийг ЭКСИМ банкинд хүргүүлснээр ЭКСИМ банк уг зөвшөөрөл болон аккредитивын дагуу холбогдох зарцуулалтыг Төлбөр хийх сүүлийн өдрөөс өмнө хийх, эрх бүхий гэрээний нийт эрх бүхий үнэ нь Зээлийн дүнгээс хэтрэхгүй байхыг хариуцна.

4. D Зээлийн хүрээнд хийгдсэн Урьдчилгаа төлбөр(үүд)-ийг татвар болон бусад холбогдох шимтгэлийг төлөхөд ашиглахыг хориглоно.

5.Зээлийн хүү:

5.1 Зээлийн хүү төлөх өдөр Зээлдэгч Урьдчилгаа бүрт хуримтлагдсан хүү, эсхүл тухайн тохиолдолд Хүү төлөх хугацаанд Зээлийн үлдэгдэлд хуримтлагдсан хүүг ЭКСИМ банкинд хүүгийн хэмжээгээр тооцож төлнө.

5.2 Урьдчилгаа бүрийг хийсэн өдрөөс хүү хуримтлагдаж эхлэх ба нэг жилд 360 хоног байхаар бодож хүүг хугацаа хэтэрсэн бодит хоног (хүү хуримтлагдаж эхлэх эхний өдрийг оруулан)-т үндэслэн тооцно.

5.3 Энэхүү Хэлэлцээрийн дагуу төлөх хугацаа нь болсон боловч төлөхгүй байж болох бусад хүүг холбогдох Хүү төлөх өдөр зохих журмын дагуу төлнө.

5.4 Дор дурдсан 8 дахь заалтад зааснаас үл хамааран урьдчилгаа болон Зээлийн үлдэгдэлд тооцсон бүх хүү, энэхүү Зээлийн хэлэлцээрийн дагуу төлөх бусад төлбөрийг зохих өдөр төлөөгүй бол тухайн өдрөөс эхлэн дээр дурдсан хүүгийн хэмжээгээр нэмэгдэл хүүг тооцох бөгөөд хагас жилд тутамд үлдэгдэл нийлмэл хүүг төлөхөд нэгтгэн төлнө.

6.Эргэн төлөлт:

6.1 Зээлдэгч нь ЭКСИМ банкинд үндсэн Зээлийн үлдэгдлийг эхний Урьдчилгаа хийгдсэн өдрөөс хойш зээлийг төлөх хугацааг хойшлуулсан таван (5) жил өнгөрсний дараа Зээлдэгч, ЭКСИМ банк эхний Эрх бүхий гэрээг байгуулах үед харилцан тохирсон эхний Урьдчилгаа хийгдсэн өдрөөс эхлэн 20 жилээс дээшгүй хугацаа (хойшлуулсан хугацааг оролцуулан)-ны дотор хагас жил тутамд харилцан адил хэмжээтэйгээр эргэн төлөхийг зөвшөөрч, үүрэг хүлээж байна. Эхний төлбөрийг дээр дурдсан хойшлуулсан хугацаа дууссан даруйд 5 дугаар сарын 10 болон 11 дүгээр сарын 10-ны

өдөр төлнө. ЭКСИМ банк нь эхний Урьдчилгааны зарцуулалт хийгдсэний дараа зээлийн эргэн төлөлтийн хуваарийг Зээлдэгчид мэдэгдэнэ. Гэхдээ ямарваа шалтгаанаар ЭКСИМ банкнаас хийсэн Урьдчилгааны нийт эцсийн дүн нь энэхүү Хэлэлцээрийн дагуу Зээлдэгчид олгохоор тохирсон Зээлийн дүнгээс бага байвал дээр дурдсан Зээлийн эргэн төлөлтийн дүнг буурах дарааллаар багасгана.

7.Төлбөр

7.1 Ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд төлөх хүү:

Зээлдэгч эрх бүхий гэрээ бүрээс зарцуулагдаагүй үлдсэн Зээлийн үлдэгдэлд жилийн 0.50% (тэг зууны тавин хувь)-иар тооцож ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд төлөх хүү (commitment fee)-г ЭКСИМ банкинд төлнө. Уг хүүг ЭКСИМ банк холбогдох гэрээг баталсан өдрөөс хойш хоёр (2) сар өнгөрсний дараагаас тооцож эхлэх ба Эрх бүхий гэрээний Эрх бүхий үнийн дүнг эцэслэн зарцуулсан өдөр, эсхүл холбогдох Зарцуулалтын сүүлийн өдрийн аль өмнөх өдөр хүү зогсоно. Ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд төлөх хүүг дээр дурдсан хоёр сарын хугацаа өнгөрсний дараа 5 дугаар заалтад заасан хагас жилийн хүүгийн хамт Хүү төлөх өдөр тухай бүр төлнө.

7.2 Удирдлагын зардал

Эксим банк Эрх бүхий гэрээг баталсан өдрөөс хойш хүү төлөх өдөр Эрх бүхий гэрээ тус бүрийн Эрх бүхий үнийн дүнд 0.50% (тэг зууны таван хувь)-ийн удирдлагын зардлыг Зээлдэгч Эксим банкинд нэг удаа төлнө.

7.3 Хэрэв ямарваа шалтгаанаар эрх бүхий гэрээний эрх бүхий үнийн дүнг бүрэн буюу хэсэгчлэн зарцуулаагүй байсан ч ЭКСИМ банк Зээлдэгчид Ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд төлсөн хүү болон удирдлагын зардлыг буцаан олгохгүй.

8.Зөрчил гарах үед төлөх хүү:

8.1 Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд Зээлдэгч ямар нэг төлбөрийн зөрчил гаргасан бол уг төлөгдөөгүй дүнд тооцогдох нэмэлт хүү (анз)-г ЭКСИМ банкинд төлнө. Анзыг төлбөр хийгдэх ёстой байсан өдрөөс төлбөрийг хийсэн өдөр хүртэл (шийдвэр гарахаас өмнө болон хойно) эхлэн Хүүгийн хэмжээнээс дээш хувиар буюу жилийн 2% (хоёр хувь)-иар тооцно.

8.2 Дээр дурдсан хүүгийн хэмжээгээр өдөр, өдрөөр хуримтлагдах бөгөөд нэг жилд 360 хоног байхаар бодож хугацаа хэтэрсэн бодит хоногт үндэслэн тооцно.



9.А. Урьдчилсан нөхцөл:

Зээлдэгчээс зохих хэлбэр, агуулга бүхий дараахь баримт бичиг буюу нотлох баримтыг хүлээн авсан тухайгаа нотолж ЭКСИМ банк Зээлдэгчид бичгээр мэдэгдэл хүргүүлснээр энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болно:

- (a) Зээлдэгчийн улсад мөрдөгдөж буй байгаль орчин, нийгэм, засаглалын харилцааг зохицуулж буй холбогдох хууль тогтоомжид төсөл нь нийцэж байгаа тухай Зээлдэгчийн баталгааг ЭКСИМ банк хүлээн авсан байх;
- (b) Зээлдэгч нь ЭКСИМ банкинд төслийн бүх хууль тогтоомж /зохицуулалтын/ төсвийн зөвшөөрөл бэлэн болсныг баталгаажуулж, Зээлдэгчийн нутаг дахь Төсөл хэрэгжүүлэх газар, зөв арга зам, суурь дэд бүтэц, цахилгаан ус зэргийг бэлэн болгох, эсхүл шаардлагатай арга хэмжээг хангасан байх;
- (c) ЭКСИМ банк нь Зээлдэгчийн татвар, гаалийн татвараас чөлөөлснийг баталгаажуулах баримт, санхүүгийн асуудлыг хаасан бичиг баримт болон Зээлдэгчийн төсөлтэй холбоотойгоор гаргасан бусад амлалтуудыг гэрээний хуулбарын хамт хүлээн авна.
- (d) Энэхүү Хэлэлцээрийн дагуу Зээлдэгч төлбөл зохих аливаа төлбөр, хүү, хураамж, зарлага зэргийг заасан хугацаанд нь ЭКСИМ банкинд төлсөн;
- (e) Энэхүү Хэлэлцээрийн Ерөнхий нөхцөлийн дагуу Зээлдэгчийн гаргах бүхий л мэдээлэл, баталгаа нь Зээлийн Урьдчилгаа гаргах тухай бүрд үнэн, зөв хэвээр байвал зохих ба өөрөөр хэлбэл урьдчилгаа хийх үед үүссэн ямарваа нөхцөл, байдалд дээрх мэдээлэл ижил байна гэсэн үг болно;
- (f) Ямарваа зөрчил гараагүй буюу үргэлжлэн гарахгүй байх;
- (g) Тухайн зарцуулалт хийх сүүлийн өдрөөс өмнө ЭКСИМ банк нь Худалдагчаас энэхүү гэрээний 4 дүгээр заалтад заасан баримт бичгүүдийг Хавсралт II-т заасан Гэрээний бүрдлийн маягтын хамт мөн Хавсралт баримт бичиг II тусгагдсан Зээлдэгчийн итгэмжлэгдсэн албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан Хавсралт III дахь Төлбөрийн зөвшөөрлийг хүлээн авсан.

9.В. Зээлдэгчийн хууль зүйн дүгнэлт (Хавсралт баримт бичиг I) болон Зээлдэгчийн гарын үсэг зурах эрх олгогдсон албан тушаалтнуудын нэрсийн жагсаалт (Хавсралт баримт бичиг II)-ыг Зээлийн хэлэлцээрт хавсаргана.

10. Авлигын эсрэг хууль:

10.1 Хэлэлцэн тохиролцогч талууд нь /дангаар, эсхүл энэхүү хэлэлцээрт оролцсон гуравдагч этгээдээр дамжуулан/ энэхүү хэлэлцээрийг байгуулах болон/эсхүл хэрэгжүүлэхэд санхүүгийн болон санхүүгийн бус давуу тал олгох, шууд буюу шууд бус амлалт өгөх зэрэг оролцогч аливаа талын үндэсний хууль тогтоомжийн дагуу эрүүгийн гэмт хэрэгт тооцогдож болох үйлдлийг болон өөртөө, эсхүл гуравдагч этгээдийн өмнөөс санал болгох, хүсэх, эсхүл хүлээн зөвшөөрөхийг хориглоно.

10.2 10.1 дүгээр зүйлд заасан үйл ажиллагаа, эсхүл нөхцөл байдалд суурилсан аливаа гэрээ нь эдгээр үйл ажиллагаанд оролцсон этгээдүүд иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээхээс үл хамааран энэхүү хэлэлцээрийн дагуу зөрчилд тооцогдох тохиолдол болно.

11. Ил тод, шударга байдал

Зээлдэгч нь энэхүү хэлэлцээрийн хүчинтэй байх хугацаанд ёс зүй, шударга байдлыг хамгийн өндөр түвшинд байлгах шаардлагатай бүх арга хэмжээг авах үүргийг үүгээр хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ худалдагч, тендерт оролцогч, нийлүүлэгч, гэрээт гүйцэтгэгч, зуучлагч, зөвлөх, туслан гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчид болон бүх ажилтан нь өөрсдийн үүрэг хариуцлагын хүрээнд Төслийн дэлгэрэнгүй тайлан бэлтгэх зэрэг тухайн төслийн хэрэгжилттэй холбоотой чиг үүрэг, тендерт шалгаруулалт явуулах, түүний гүйцэтгэлийн явцад үүргээ тус тус ноцтой зөрчих явдлаас сэргийлэхэд боломжит, шаардлагатай бүх арга хэмжээг авах нөхцөлийг баталгаажуулна.

12. Зээлийн хэлэлцээрийн бүрэлдэхүүн хэсэг болох Ерөнхий нөхцөл:

Энэхүү Хэлэлцээр нь Хуваарьт заасан Ерөнхий нөхцөлийн хамт нэг хэлэлцээр хэмээн тооцогдоно. Ерөнхий нөхцөл нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг энэхүү Хэлэлцээрт ишлэн оруулсанд тооцно. Талууд Ерөнхий нөхцөлийн заалтыг хүлээн зөвшөөрч, заавал дагаж мөрдөхөөр тохиролцов.

ХУВААРЬ

Ерөнхий нөхцөл

- A. Тодорхойлолт ба тайлбар
- B. Зээлдэгчийн хүлээх үүрэг
- C. Хүү төлөх хугацаа



- D. Татвар
- E. Дансны мөнгөн тэмдэгт болон төлбөр хийх газар
- F. Төлбөрийн зориулалт
- G. Нөхөн төлбөр
- H. Мэдэгдэл
- I. Хэлцэл хийх нөхцөл
- J. Хяналт шалгалт, мониторинг
- K. Зөрчил тооцогдох тохиолдол
- L. Өрийн нотолгоо
- M. Татгалзал
- N. Эрх шилжүүлэх
- O. ЭКСИМ банкны баталгаажуулалт
- P. Хэсэгчлэн хүчингүй болох
- Q. Баримт бичгийн хэл
- R. Хууль
- S. Арбитр
- T. Мэдэгдэл

ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

A. Тодорхойлолт ба тайлбар:

Энэхүү хэсэгт өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд Зээлийн хэлэлцээрт тодорхойлсон, энэхүү Ерөнхий нөхцөлд хэрэглэгдэж буй бүх үг хэллэг нь Зээлийн хэлэлцээрт заасантай ижил утгатай байна. Зээлийн хэлэлцээрийн заалт болон Ерөнхий нөхцөлийн заалт хооронд зөрүү гарвал Зээлийн хэлэлцээрийн заалтыг баримтална.

B. Зээлдэгчийн хүлээх үүрэг:

Энэхүү Хэлэлцээрийн дагуу Зээлдэгчийн төлбөр хийх үндсэн үүрэг нь ямар ч тохиолдолд Худалдагч эрх бүхий гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлсэн эсэхээс үл хамаарах бөгөөд түүнчлэн Худалдагч, Худалдан авагчийн хооронд гарсан аливаа маргаан, Худалдагчийн эсрэг нэхэмжлэл гаргах Худалдан авагчийн эрх үүнд нөлөөлөхгүй. Тэрчлэн Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрийн дагуу ЭКСИМ банкинд төлөх аливаа төлбөрийг шийдвэрлэх үүднээс өөрийн Худалдан авагчтай тогтоосон ажил хэргийн буюу гэрээний харилцаатай холбогдуулан ямар нэг хориг арга хэмжээ авах эрхгүй.

C. Хүү төлөх хугацаа:

- (1) Урьдчилгаа, эсхүл Зээлийн үлдэгдэлтэй хугацаа нь 6 сар, эсхүл тухайлан түүнээс өөрөөр тогтоосон хугацаа бүхий дараалсан хугацаанд (“Хүү төлөх хугацаа” гэх) хуваагдана.
- (2) Урьдчилгаа бүрийн эхний хүү төлөх хугацаа нь Урьдчилгаа хийсэн өдрөөс эхлэх бөгөөд эхний эрх бүхий гэрээний эхний урьдчилгааны хувьд анхны хүү төлөх хугацаа нь тухайн хүү төлөх хугацааны Хүү төлөх өдөр дуусгавар болно.
- (3) Өмнөх эрх бүхий гэрээ, эсхүл өөр эрх бүхий гэрээний дараа дараагийн Урьдчилгаа бүрийн хувьд эхний хүү төлөх хугацаа нь эхний эрх бүхий гэрээний эхний Урьдчилгааны хүү төлөх хугацааны сүүлийн өдөр дуусгавар болно.
- (4) Хүү төлөх хугацаа бүр (Урьдчилгаа бүрийн эхний хүү төлөх хугацаанаас бусад) өмнөх хүү төлөх хугацааны дараагийн өдөр шууд эхлэх бөгөөд хамгийн ойрын Хүү төлөх өдөр дуусгавар болно.
- (5) Аливаа хүү төлөх хугацаа өмнөх сарын дундуур дуусах буюу эсхүл сүүлийн Эргэн төлөх өдрөөс хэтрэх бол уг хугацаа E.4 хэсэгт зааснаар дуусгавар болно.
- (6) Хэрэв хоёр ба түүнээс дээш хүү төлөх хугацааны эхлэх, дуусах өдөр нь нэг өдөр байвал тухайн хүү төлөх хугацаанд хамаарах Урьдчилгааг нэгтгэж нэг Урьдчилгаа гэж тооцно.

D. Татвар:

D.1 Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрийн дагуу төлөх бүх төлбөрийг түүнд өөрчлөлт оруулах, сөрөг нэхэмжлэл гаргах буюу ямар нэг болзол, хязгаарлалтгүйгээр Зээлдэгчийн улсын Засгийн газраас одоо болон цаашид ногдуулах бүх төрлийн татвар, суутгал, шимтгэл (“Татвар” гэх)-ийг үл оролцуулан бүрэн төлнө. Хэрэв (i) хуульд зааснаар Зээлдэгч энэхүү Хэлэлцээрийн дагуу хийх ямарваа төлбөрөөс суутгал тооцох буюу шимтгэл авах шаардлагатай бол, эсхүл; (ii) хуулийн дагуу ЭКСИМ банк энэхүү Хэлэлцээрийн дагуу хүлээн авсан буюу хүлээн авах төлбөртэй холбогдуулан татвар (нийт орлогод ногдох татвараас бусад) төлөх шаардлагатай, эсхүл Зээлийн сан бий болгох зорилгоор өөрийн Зээлдүүлэгч (нар)-ээс авсан зээлийг төлөх болбол Зээлдэгч төлбөр хийхдээ суутгал, шимтгэл, төлбөр зэргийг тооцон төлбөрийн дүнг нэмэгдүүлэх ба тэдгээр суутгал, шимтгэл, төлбөрийг тооцсоны дараа ЭКСИМ банк авбал зохих суутгал, шимтгэл буюу аливаа төлбөр тооцоогүй мөнгөн дүнг авна (суутгал, шимтгэл, төлбөр зэргийн талаар ямарваа үүрэг хүлээхгүй).

D.2 Хуулийн дагуу Зээлдэгчийн хийх төлбөрөөс аливаа суутгал, шимтгэл авсан тохиолдолд Зээлдэгч тэрхүү төлбөрөөс суутгал, шимтгэл



тооцсоныг нотлох холбогдох татварын буюу бусад байгууллагын баримтыг төлбөр хийснээс хойш 30 хоногийн дотор ЭКСИМ банкинд хүргүүлнэ.

D.3 Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээр (хууль ёсны болсон эсэхээс үл хамааран)-ийн дагуу төлөх аливаа төлбөр, эсхүл ямар нэг татвар төлөх үүрэг хариуцлагыг ЭКСИМ банкинд хүлээлгэхгүй.

D.4 Хэрэв Зээлдэгч нь энэ хэсгийн (1)-д заасан суутгал, шимтгэл, эсхүл төлбөр хийж болзошгүй тохиолдолд үүсвэл ЭКСИМ банкинд нэн даруй мэдэгдэж, боломжтой бүх мэдээллийг гаргаж өгнө.

Е. Дансны мөнгөн тэмдэгт болон төлбөр хийх газар:

E.1 Энэхүү Хэлэлцээрийн дагуу төлбөрийн дансны мөнгөн тэмдэгт нь ам.доллар байх бөгөөд Зээлдэгч Зээлийн хэлэлцээрийн дагуу ямар ч үед төлбөрийг ам.доллараар хийнэ.

E.2 (i) Хэрэв энэхүү Хэлэлцээрийн дагуу, эсхүл тодорхой шийдвэрийн талаар гарсан арбитрын шийдвэрийн дагуу Зээлдэгчийн төлөх аливаа төлбөрийн дүнг (i) Зээлдэгчийн эсрэг нэхэмжлэл, нотолгоо гаргах, (ii) тодорхой шийдвэрийн талаар арбитрын шийдвэр гаргуулах, (iii) тухайн арбитрын шийдвэрийг биелүүлэх зэрэг зорилгоор дээрх мөнгөн тэмдэгт (“Анхны мөнгөн тэмдэгт”)- ээс өөр мөнгөн тэмдэгт (“Хоёрдогч мөнгөн тэмдэгт”) рүү хөрвүүлэх шаардлагатай бол дээрх нэхэмжлэл, нотолгоог гаргасан, эсхүл арбитрын шийдвэр гарсан өдрийн өмнөх ажлын өдөр дуусах үеийн, арилжааны банкнаас ЭКСИМ банкинд санал болгосон чөлөөтэй шилжих долларын арилжааны ханшаар тооцож хөрвүүлнэ. Ингэхдээ Зээлдэгч нь (a) төлбөрийг анхны мөнгөн тэмдэгтээс хоёрдогч мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэх арилжааны ханш болон (b) тухайн нэхэмжлэл, арбитрын шийдвэрийн дагуу холбогдох мөнгөн дүнг бүрэн буюу хэсэгчлэн төлсөн тухай баримтыг хүлээн авснаар ердийн үед ЭКСИМ банк хоёрдогч мөнгөн тэмдэгтээр анхны мөнгөн тэмдэгтийг худалдан авах арилжааны ханш хоорондын зөрүүнээс үүдэн ЭКСИМ банкинд аливаа алдагдал учрахаас сэргийлж, учирсан хохирлыг нөхөн төлнө.

(ii) Хэлэлцээрийн E.2(i) дэд хэсгийн зорилгоор болон дээр дурдсан нөхөн төлбөрийн талаарх зохицуулалтыг хөндөхгүйгээр, хэрэв шүүхийн тодорхой шийдвэрийн талаар гарсан арбитрын шийдвэр хоёрдогч мөнгөн тэмдэгтээр хийгдсэн бол энэ нь ердийн үед ЭКСИМ банк хоёрдогч мөнгөн тэмдэгтээр анхны мөнгөн тэмдэгтийг худалдан авахад ашиглах төлбөр хийх өдрийн арилжааны ханшаар тооцсон зохих дүн бүхий төлбөрийг анхны мөнгөн тэмдэгтээр хүлээн авах бололцоотойгоор хийгдсэн байхыг хуулиар зөвшөөрөгдөх хүрээнд баталгаажуулахыг Зээлдэгч зөвшөөрөв.

E.3 Зээлдэгч ЭКСИМ банкинд төлөх бүх төлбөрийг доллароор хийх бөгөөд ЭКСИМ банкны Энэтхэг Улс дахь тусгайлан заасан банк,

эсхүл гадаад улсын банкин дахь дансанд шилжүүлнэ. Төлбөрийг ЭКСИМ банк валютын харьцуулсан нэрийтгэл ханшаар төлбөр хийх өдөр буюу түүнээс өмнө хүлээж авах боломжтой байхаар хийнэ. ЭКСИМ банк өөрөөр тусгайлан мэдэгдээгүй бол, Зээлдэгч төлбөрийг ЭКСИМ банкны Exim Bank A/c. No. 36247347, Citibank N.A., New York, U.S.A., CHIPS UID 173871 дансанд шилжүүлнэ. Төлбөрийг аливаа суутгалгүйгээр ЭКСИМ банкны заасан дансанд шилжүүлж, тус банк чөлөөтэй захиран зарцуулах боломжийг бүрдүүлснээр Зээлдэгч төлбөр хийх үүргээ биелүүлсэн гэж тооцно.

Е.4 Хэрэв Зээлийн хэлэлцээрийн дагуу төлбөр хийх өдөр нь тухайн төлбөр хийх газар, эсхүл ЭКСИМ банкны хувьд ажлын бус өдөр байвал дараагийн ажлын өдөр төлбөрийг хийнэ. Хэрэв тэрхүү дараагийн ажлын өдөр нь дараагийн хуанлийн сард тохиож буй бол төлбөрийг өмнөх ажлын өдөр хийх ба шаардлагатай тохиолдолд хүү болон хураамжийг зохих ёсоор тооцно.

F. Төлбөрийн зориулалт:

F.1 Хэрэв ЭКСИМ банк шаардаагүй бол энэхүү Зээлийн хэлэлцээрийн дагуу ЭКСИМ банкинд төлөх төлбөр нь дор дурдсан зориулалттай байх ба Зээлдэгч өөр ямар нэг зориулалтаар төсөвлөх эрхгүй:

- (a) Үнэ ба зардал;
- (b) Төлбөр;
- (c) Анзын хэлбэрээр тооцох нэмэлт хүү;
- (d) Нийлмэл хүү;
- (e) Хүү;
- (f) Зээлийн хэлэлцээрийн дагуу төлөх үндсэн төлбөр.

F.2 Дээрх (1) дэд хэсэгт зааснаас үл хамааран, ЭКСИМ банк нь өөрийн эрх хэмжээний хүрээнд Зээлдэгчийн ЭКСИМ банкинд төлбөл зохих бусад зээл буюу үндсэн зээлийн төлбөрт дээрх төлбөрийг зориулан төсөвлөж болно.

G. Нөхөн төлбөр:

Зээлдэгч Зээлийн хэлэлцээрээр хүлээсэн үүргээ зөрчсөн, эсхүл зөрчилд тооцогдох тохиолдол илэрсэн, эсхүл зээлийн аливаа хэсгийг буюу хугацаа хэтэрсэн төлбөрийг ЭКСИМ банкинд зохих эргэн төлөх өдөр буюу хүү төлөх өдрөөс хугацаа хоцроож төлсөн, нөхөн төлсөн зэргээс шалтгаалан ЭКСИМ банкинд учирсан бүхий л алдагдал, өр, хохирол, зардал, төлбөр болон зарлага (үүнд Зээлийг бүрдүүлэх, эсхүл Урьдчилгаа төлөх болон төлөгдөөгүй үнийн дүнг санхүүжүүлэхэд гарсан аливаа зардал, хүүг шийдвэрлэх зорилгоор бий болгож төвлөрүүлсэн хөрөнгийг



нөхөн төлөхтэй холбоотойгоор гарсан зардал мөн хамаарна) зэргийг түүний нотолсноор нөхөн төлнө.

Н. Мэдэгдэл, баталгаа:

Н.1 Зээлдэгч нь дараахь зүйлсийг мэдэгдэж байна:

- (i) Энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан албан тушаалтан(ууд) нь Зээлийн хэлэлцээрийг Зээлдэгчийн нэрийн өмнөөс байгуулах, хэрэгжүүлэх бүрэн эрх, эрх зүйн чадамжтай ба Зээлдэгчид олгох зээлийг батлах, Зээлийн хэлэлцээр болон түүнд холбогдох бүхий л баримт бичгийг байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэхэд шаардлагатай (хуульд заасан болон бусад) арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болохыг;
- (ii) а) Зээлдэгч Зээлийн хэлэлцээрийг байгуулах, түүгээр олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах, б) Зээлийн хэлэлцээрийн дагуу хүлээхээр заасан үүрэг нь хууль ёсны, үндэслэлтэй, хэрэгжүүлэх бололцоотой байхыг тус тус хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг Зээлдэгчийн улсын хууль тогтоомжид чанд нийцүүлэн авч хэрэгжүүлсэн бөгөөд тэдгээр нөхцөлүүдийг биелүүлэх явцад аливаа зөрчил гараагүй болохыг;
- (iii) Зээлийн хэлэлцээрийн дагуу Зээлдэгчийн хүлээхээр заасан үүрэг, хариуцлага нь Зээлдэгчийн хууль ёсны, хүчин төгөлдөр дагаж мөрдөх, түүнчлэн ямарваа нөхцөл болзолгүйгээр шууд хүлээх нийтлэг үүрэг хариуцлага бөгөөд эдгээр нь түүний бусад үүрэг хариуцлагатай ижил түвшинд тооцогдох болохыг;
- (iv) Зээлийн хэлэлцээр болон Төлбөрийн нотолгооны хууль ёсны, хүчин төгөлдөр, үндэслэлтэй, хэрэгжүүлэх боломжтой байдлыг Зээлдэгчийн улсад баталгаажуулах үүднээс тэдгээр болон өөр бусад баримт бичгийг мэдээллийн санд оруулах, нотариатаар баталгаажуулах, бүртгэх, тэмдэглэх буюу аливаа шүүх, эрх бүхий байгууллагын бүртгэлд оруулах, тамга дарах, бүртгэх, Зээлийн хэлэлцээр болон түүнтэй холбогдуулан аливаа татвар төлөх шаардлагагүй болохыг;
- (v) Зээлийн хэлэлцээр болон түүний дагуу байгуулагдсан баримт бичгийн дагуу хүлээх үүрэгтэй холбоотойгоор Зээлдэгч нь иргэний болон худалдааны хууль тогтоомжид захирагдаж, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэгдэх ажиллагаанд харьяалагдах ба зээл авах ажиллагаа, Зээлийн хэлэлцээрийг байгуулах, Зээлдэгч түүний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх зэрэг нь төрийн бус харин хувийн, арилжааны үйл ажиллагаанд тооцогдоно. Зээлдэгч буюу түүний өмч, хөрөнгө, орлогын алин боловч шүүхэд дуудагдах,

хураагдах /шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхээс өмнө буюу шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлж буй аль ч үед/, нөхөн төлөх, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх болон бүрэн эрхт байдлын буюу бусад үндэслэлээр Зээлдэгчийн улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хамгаалагдах халдашгүй дархан байдал, онцгой эрх олгогдохгүйгээс гадна энэхүү Хэлэлцээрт тусгасан халдашгүй дархан байдал, онцгой эрхээс татгалзах үүргийг Зээлдэгч заавал биелүүлэх болохыг;

- (vi) Зээлийн хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зээлдэгчийн улсад явагдах аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Зээлийн хэлэлцээрийг зохицуулах хуулиар Энэтхэг Улсын хуулийг сонгосон нь хүчин төгөлдөр бөгөөд Зээлийн хэлэлцээртэй холбоотойгоор гарсан шүүхийн аливаа тогтоол, шийдвэр, эсхүл арбитрын шийдвэрийг Зээлдэгчийн улсын шүүх хүлээн зөвшөөрч, биелүүлэхийг;
- (vii) ЭКСИМ банк нь зөвхөн Зээлийн хэлэлцээрийг байгуулж, хэрэгжүүлэх шалтгаанаар Зээлдэгчийн улсад байнга байрлах буюу үйл ажиллагаа явуулахгүй.

Н.2 Зээлдэгч нь мөн дараахь зүйлсийг мэдэгдэж байна:

- (i) Зээлийн хэлэлцээр, эсхүл Төлбөрийн зөвшөөрлийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх болоод Зээлдэгч Зээлийн хэлэлцээрээр олгогдсон эрхээ эдлэх нь:
 - (a) Зээлдэгчийн заавал биелүүлэх буюу түүний одоогийн болон ирээдүйн хөрөнгө орлогод үйлчлэх аливаа хууль тогтоомж, зөвшөөрөл, шүүхийн шийдвэр, тогтоол, хэлэлцээр, баримт бичиг болон үүргийг зөрчихөд хүргэх буюу тэдгээртэй зөрчилдөхгүй,
 - (b) Зээлдэгчийн одоогийн болон ирээдүйн хөрөнгө, орлогод бүхэлд нь буюу түүний тодорхой хэсэгт хориг саад учруулах, эсхүл Зээлдэгчид дээрх хориг саадыг бий болгох үүрэг ногдуулахгүй;
- (ii) Зээлдэгч Зээлийн хэлэлцээрээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх чадавхид бодит сөрөг нөлөө үзүүлэхүйцээр, Зээлдэгчийн заавал биелүүлэх буюу түүний одоогийн болон ирээдүйн хөрөнгө орлогод үйлчлэх аливаа хууль тогтоомж, зөвшөөрөл, хэлэлцээр, баримт бичиг болоод үүргийг зөрчөөгүй болохыг;
- (iii) Зээлийн хэлэлцээрийн дагуу хүлээсэн төлбөр төлөх үүргээ биелүүлэх зорилгоор Зээлдэгчийн хийх гадаад мөнгөн шилжүүлэгт тогтоосон аливаа хязгаарлалт, саад байхгүй болохыг;
- (iv) К.1 хэсэгт дурдсан тохиолдол, эсхүл тэдгээр тохиолдолд тооцогдох (мэдэгдэл хүргүүлснээр, тодорхой хугацаа өнгөрснөөр,



эс бөгөөс бодит нөхцөл байдлаас улбаалсан) магадлал бүхий тохиолдол үүсээгүй, түүнчлэн заасан хугацаанаас өмнө өрөө төлж барагдуулахыг Зээлдэгчид мэдэгдэх, Зээлдэгчид аливаа зээл олгохыг, зогсоох, цуцлах, эсхүл урьдчилгаа төлөхөөс татгалзах зэрэг эрхийг түүний зээл олгогчид олгож буй буюу мэдэгдэл хүргүүлсэн нөхцөлд болон хугацаа дуусахад ийм эрх олгохуйц тохиолдол үүсээгүй гэдгийг; мөн

- (v) Энэхүү Хэлэлцээрийг байгуулсан өдрөөс өмнө Зээлдэгчээс ЭКСИМ банкинд гаргаж өгсөн мэдээлэл нь үнэн, зөв бөгөөд алдаагүй, аливаа төөрөгдүүлэх утга агуулаагүй болох.

I. Хэлцэл хийх баталгаа:

Зээлдэгч дор дурдсан зүйлсийг гүйцэтгэхийг зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээж байна. Үүнд:

- (i) Зээлийн хөрөнгийг Зээлдэгчийн улсын Худалдан авагч Энэтхэг Улсаас Эрх бүхий барааг худалдан авахад зарцуулах;
- (ii) Зээлдэгч Зээлийн хэлэлцээрийг хууль ёсны дагуу байгуулах, Зээлийн хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх, түүнчлэн Зээлийн хэлэлцээрийг хууль ёсоор хүчин төгөлдөр болгох, хэрэгжүүлэхэд Зээлдэгчийн улсын хууль тогтоомжийн дагуу шаардагдах бүх зөвшөөрөл, баталгаа, лиценз зэргийг авч, мөрдөж ажиллах;
- (iii) К. 1 хэсэгт дурдсан тохиолдол, эсхүл тэдгээр тохиолдолд тооцогдох магадлал бүхий (мэдэгдэл хүргүүлснээр, тодорхой хугацаа өнгөрснөөр, эс бөгөөс бодит нөхцөл байдлаас улбаалсан) аливаа тохиолдлын талаар ЭКСИМ банкинд нэн даруй мэдэгдэх;
- (iv) Зээлдэгч буюу түүний аливаа хөрөнгийн эсрэг шүүхэд зарга мэдүүлсэн, арбитрын шүүхэд хандсан, захиргааны арга хэмжээ авсан, эсхүл гэрээний дагуу нэхэмжлэл гаргасан зэрэг Зээлдэгчийн Зээлийн хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх чадавх, эсвэл санхүүгийн байдалд бодит хохирол учруулах буюу сөргөөр чөлөөлж болзошгүй үйлдлүүдийн талаар ЭКСИМ банкинд нэн даруй мэдэгдэх;
- (v) Зээлийн хэлэлцээрийн дагуу хүлээх үүргээ Зээлдэгч ямагт аливаа нөхцөл болзолгүйгээр, шууд хэрэгжүүлэх ба нийтлэг үүрэг, хариуцлага түүний бусад үүрэг, хариуцлагатай ижил түвшинд авч үзэх;
- (vi) зардлын хэтрэлт, нөөцийн дутагдалтай байдлыг зохицуулж төслийг бүрэн хэрэгжүүлж дуусгах;
- (vii) Хэрэв Зээлдэгчийн улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн бүртгэл, тооцоо хийх зарчим, тогтсон журмын дагуу шаардагдах

санхүүгийн нөөц бололцоог бүрдүүлээгүй бол Зээлдэгч хэрэв эс төлөх аваас Зээлдэгчийн хөрөнгө, ашиг, орлогод хохирол учруулж болохуйц бүх төрлийн хууль ёсны нэхэмжлэлийг төлөх буюу төлөх арга хэмжээ авах;

- (viii) Өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг Мумбай хотод томилон ажиллуулах ба Зээлийн хэлэлцээрийн дагуу ЭКСИМ банкинд төлбөл зохих бүх төлбөрийг төлж дуусах хүртэл хэрэв ЭКСИМ банк хүлээн зөвшөөрсөн өөр итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсноос бусад тохиолдолд тэрхүү төлөөлөгчөөр дамжуулан харилцах харилцааг зогсоохгүй. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн томилгоо, түүний хаягийн өөрчлөлт, явцдаа буй томилгоо зэргийн талаар ЭКСИМ банкинд мэдэгдэх ба тэдгээрийн хувийг шуудангийн үйлчилгээний хураамжийг урьдчилан төлж захиалгат шуудангаар Хэлэлцээрт заасан Зээлдэгчийн хаягаар хүргүүлсэн нь Зээлдэгчийн зөвшөөрлөөр хийгдэж буй хувийн үйлчилгээ хэмээн үзэх ба энэ нь арбитрын шүүхэд лавлагааны зорилгоор ашиглахад заавал биелэгдэх шинжтэй байна.

Ж.Хяналт шалгалт, мониторинг:

Ж.1 Хяналт шалгалт

Зээлдэгч Зээлийн хэлэлцээрийн дагуу төлбөл зохих бүх төлбөрийг төлж барагдуулах хүртэл ЭКСИМ банкны төлөөлөгчид Худалдан авагчийн авсан зээл, үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэл тооцоонд хяналт шалгалт хийхэд туслалцаа үзүүлж, тэдгээрийн ажилтан, албан хаагчид нь бүрэн хамтарч ажиллахыг хариуцна. ЭКСИМ банк нь хяналт шалгалт хийх эрхээ хязгаарлагдмал хүрээнд хэрэгжүүлэх ба уг хяналт шалгалт нь ЭКСИМ банкны хөрөнгөөр санхүүжигдэж буй Худалдан авагчийн төслийн хүрээнд хийгдэнэ хэмээн ойлгоно.

Зээлдэгч нь Худалдагч, тендерт оролцогч, нийлүүлэгч, гэрээлэгч, зөвлөхүүд, ажилтнууд, дэд гэрээлэгч, үйлчилгээ үзүүлэгч, болон бусад холбогдох ажилтнуудтай зөвшилцөж, сонгон шалгаруулалт болон гэрээний гүйцэтгэлтэй холбоотой данс, тайлан болон бусад холбогдох баримт бичгүүдийг хянан шалгах, мөн энэхүү хэлэлцээрийн хугацаанд Энэтхэгийн Улсын Засгийн газар/ЭКСИМ банкнаас томилсон аудиторар аудит хийлгэх эрхийг Энэтхэг Улсын Засгийн газар/ЭКСИМ банкинд олгоно.

Зөрчилд тооцогдох тохиолдол үүссэн болон энэхүү байдал нь үргэлжилсэн тохиолдолд Зээлдэгч нь Энэтхэгийн Засгийн газар/ЭКСИМ банкнаас Худалдан авагчийн төслийн хяналт шалгалт хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

**J.2 Төсөл(үүд)-д мониторинг хийх /Эрх бүхий гэрээ (нүүд)**

- a) Зээлдэгч нь Эрх бүхий гэрээний гүйцэтгэлийн явцын тайланг Эрх бүхий гэрээ батлагдсанаас хойш гэрээ дуусах хүртэлх хугацаанд 3 сар тутамд хүргүүлнэ.
- b) Зээлдэгч өөрийн зардлаар Төсөл /эрх бүхий гэрээ хэрэгжиж дуусах үед төслийн хүрээнд гарсан үр ашиг/төслөөс гарах үр ашиг болон төслийн Зээлдэгч улсад үзүүлсэн нийгэм, эдийн засгийн бодит үр нөлөөллийг тусгасан дэлгэрэнгүй тайланг боловсруулж, хүргүүлнэ.
- c) ЭКСИМ банк төслийн бие даасан мониторинг хийх Зээлдүүлэгчийн инженерийг томилж болно. Зээлдүүлэгчийн инженер нь цаг хугацааг баримталсан байдал, чанарын үзүүлэлтийг баталгаажуулж, шаардлагатай тохиолдолд төслийг хугацаанд нь хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг санаачилж болно. Зээлдэгч тухайн төслийн гүйцэтгэгч, худалдагч, зөвлөхүүд Зээлдэгчийн инженерт шаардлагатай туслалцаа, дэмжлэг үзүүлэхэд анхаарч ажиллана.
- d) Зээлдэгч нь Зээлийн хүчинтэй хугацаанд Зээлдэгчийн Улсад байрлах төсөл хэрэгжүүлэх газарт нэвтрэх зөвшөөрлийг ЭКСИМ банк/ Энэтхэг Улсын Засгийн газрын төлөөлөгчдөд олгоно.

К. Зөрчилд тооцогдох тохиолдол:

К.1 Энэхүү заалтын зорилгоор дараахь тохиолдлуудыг зөрчилд тооцно. Үүнд:

- (a) Зээлийн хэлэлцээрийн дагуу Зээлдэгч ЭКСИМ банкинд төлбөр зохих төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол;
- (b) Зээлийн хэлэлцээрийн дагуу хүлээсэн бусад үүргээ Зээлдэгч даган биелүүлж чадаагүй бол;
- (c) Зээлдэгчээс ЭКСИМ банкинд гарган өгсөн аливаа мэдээлэл, тайлбар нь бүрэн бус буюу алдаатай бол;
- (d) Зээлдэгч ямарваа бусад гадаад өрийг хугацаанд нь үл төлсөн зөрчил гаргасан, эсхүл Зээлдэгч, түүний байгууллагын гадаад өрийн төлөхөд хориг, хязгаарлалт тавигдахаас өмнө өрийг төлөх хугацаа нь болсон, эсхүл аливаа улс төрийн шинжтэй үйл явдлын улмаас Зээлдэгчийн улс Энэтхэг Улстай таагүй нөхцөл байдал үүссэн бол;
- (e) Зээлийн хэлэлцээрийн дагуу хүлээсэн төлбөр төлөх үүргээ биелүүлэх зорилгоор Зээлдэгч гадаад мөнгөн шилжүүлэг хийхэд Зээлдэгчийн улсын хууль тогтоомжоор аливаа хязгаарлалт тогтоосон.

К.2 Хэрэв зөрчилд тооцогдох тохиолдол илрэн, энэ тухай ЭКСИМ банк Зээлдэгчид мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор түүнийг засаж залруулах аливаа арга хэмжээ аваагүй бол ЭКСИМ Банк Зээлдэгчид дараахь мэдэгдлийг бичгээр хүргүүлнэ. Үүнд:

- (а) Зээлдэгчийн Зээлийн хөрөнгийг ашиглах эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлэх ба тийнхүү түдгэлзүүлэх болсон нөхцөл байдал ЭКСИМ банкны шаардлагыг хангахуйц хэмжээнд арилах хүртэл Зээлийн хөрөнгийг түдгэлзүүлнэ. Дээрх нөхцөл байдал арилсан тохиолдолд ЭКСИМ банк Зээлдэгчийн Зээлийн хөрөнгийг ашиглах эрхийг сэргээснийг Зээлдэгчид мэдэгдэнэ;
- (б) Зээлийн ашиглагдаагүй хэсгийг цуцлах;
- (с) ЭКСИМ банкнаас зээлдэгчид шинэ буюу нэмэлт зээл олгохгүй;
- (д) Тухайн тохиолдлоос хамааран бүх Урьдчилгаа, эсхүл Зээлийн төлөгдөөгүй үндсэн дүн, түүнчлэн бодогдсон хүү болон ЭКСИМ банкинд төлөх ёстой бусад төлбөрийг Зээлдэгч /Зээлийн хэлэлцээртэй зөрчилдсөн тохиолдол үүсэхийг үл харгалзан/ ямар нэг мэдэгдэл, шаардлага гаргахгүйгээр ЭКСИМ банкинд төлнө. Зээлдэгч нь дээр дурдсан мэдэгдэл, шаардлагыг гаргахаас татгалзана.

К.3 Зөрчилд тооцох тохиолдол үүссэнтэй холбоотойгоор Зээлдэгчийн хөрөнгийг битүүмжлэх, Зээлийн хэлэлцээрийн дагуу төлөх хугацаа нь болсон төлбөрийг хураахтай холбоотойгоор ЭКСИМ банкнаас гарсан бүх зардлыг Зээлдэгч төлөх ба тийнхүү төлөх хүртэл Зээлийн хэлэлцээрт заасан хувиар анз тооцохоос гадна Хүүгийн хэмжээгээр хүү бодогдоно.

К.4 Дээр дурдсан зөрчилд тооцогдох тохиолдолтой холбоотойгоор түдгэлзүүлэх, цуцлах, шаардах зэрэг арга хэмжээ авахаас үл хамааран Зээлийн хэлэлцээрийн бүх заалт Зээлдэгчийн ЭКСИМ банкинд төлбөл зохих төлбөр төлөгдөөгүй байх хугацаанд бүрэн хүчин төгөлдөр үйлчилнэ. Түүнчлэн Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрээр хүлээсэн үүргээс ангид, дээр дурдсанчлан Зээлийн хөрөнгийг ашиглахыг түдгэлзүүлэх, зээлийн ашиглагдаагүй хэсгийг цуцлах зэргээс шалтгаалан Худалдагч, эсхүл Худалдан авагчийн зүгээс ЭКСИМ банкны эсрэг авсан аливаа арга хэмжээнээс учрах /шууд буюу шууд бус/ хохирлыг ЭКСИМ Банкинд нөхөн төлөхийг зөвшөөрнө.

Л. Өрийн нотолгоо

- (а) ЭКСИМ банк өөрийн ердийн журмын дагуу Зээлдэгчийн нэр дээр, ЭКСИМ банкнаас тухай бүр зээлж буй дүн, ЭКСИМ банкинд эргүүлэн төлөх ёстой мөнгөн дүн болон түүхий төлбөрт хүлээн авсан мөнгөн дүнг хянах зээлийн данс, түүнчлэн төлөх хүүгийн хэмжээ ба Зээлийн хэлэлцээрийн дагуу төлөгдөх бусад мөнгөн дүн, хүүгийн төлбөрт хүлээн авсан мөнгөний хэмжээ зэргийг хянах хүүгийн дансыг нээн ажиллуулна.



- (b) Зээлийн хэлэлцээртэй холбоотойгоор хийгдэх аливаа үйл ажиллагааны хувьд дээр дурдсан дансанд хийгдсэн гүйлгээ зэрэг нь Зээлдэгчийн хүлээх хариуцлагын хангалттай нотолгоо болно.

М. Татгалзал:

Зөрчилд тооцогдох тохиолдол гарсан үед Зээлийн хэлэлцээр болон бусад хэлэлцээр, эсхүл тэдгээрийн дагуу байгуулагдсан баримт бичгүүдийн дагуу ЭКСИМ банк эдлэх эрх, мэдлээ хэрэгжүүлээгүй, эсхүл зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй буюу хойшлуулсан нь тэдгээр эрх мэдэл, боломжийг сулруулах буюу түүнээс татгалзаж буйг илтгэхгүй хийгээд Зээлдэгч хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээсээ татгалзах шалтгаан болохгүй ба мөн зөрчлийг хүлээн зөвшөөрч буй мэтээр ойлгохгүй. Тэрчлэн аливаа зөрчил илэрсэн үед ЭКСИМ банкны үйлдэл, эс үйлдэл нь, эсхүл аливаа зөрчилтэй эвлэрэх зэрэг нь бусад зөрчлийн үед ЭКСИМ банкны эдлэх эрх, мэдэл, зөрчлийг арилгах арга хэмжээ авахад нөлөөлөхгүй. Зээлийн хэлэлцээрт тусгагдсан эрх, зөрчлийг арилгах арга зам зэрэг нь нэгэн цогц бөгөөд үүнд ямарваа бусад үндэслэлээр ЭКСИМ банкинд олгогдсон эрх хэмжээ мөн багтана.

Н. Эрх шилжүүлэх:

ЭКСИМ банк нь Зээлийн хэлэлцээрийн дагуу өөрт олгогдсон эрх, хүртэх үр ашгийг хэдийд ч Энэтхэг Улсын дотор, эсхүл түүний гадна буй аливаа этгээдэд дамжуулах, тараан өгөх, эсхүл хэсэгчлэн эдлэх боломж олгох эрхтэй байна. Харин Зээлдэгч Зээлийн хэлэлцээрээр хүлээсэн эрх, үүргээ шилжүүлэх эрхгүй байна.

О. ЭКСИМ банкны баталгаажуулалт:

Зээлийн хэлэлцээрийн аливаа заалттай холбоотойгоор ЭКСИМ банк хүүгийн ханш, эсхүл Зээлдэгчийн төлөх мөнгөн дүнг батлах буюу тодорхойлох, эсхүл ямарваа асуудлаар саналаа илэрхийлэх боломжтой бөгөөд уг баталгаажуулалт тодорхойлолт болон санал зэргийн эсрэг сөрөг мэдэгдэл гараагүй тохиолдолд Зээлдэгчийн хувьд заавал дагаж мөрдөх эцсийн шийдвэр байна.

Р.Хэсэгчлэн хүчингүй болох:

Хэрэв Зээлийн хэлэлцээрийн аль нэг заалт ямарваа нэг эрх зүйн тогтолцооны хууль тогтоомжийн дагуу хэдийд ч хууль бус, хүчингүй, эсхүл хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Хэлэлцээрийн бусад заалт аливаа бусад эрх зүйн тогтолцооны хууль тогтоомжийн дагуу хууль ёсны, хүчин төгөлдөр, хэрэгжих боломжтой байхад нөлөөлөхгүй.

Q. Баримт бичгийн хэл:

Зээлийн хэлэлцээрийн хүрээнд холбогдох бүх баримт бичгийг англи хэлээр үйлдэнэ.

R. Хууль:

Энэхүү Зээлийн хэлэлцээрийг Энэтхэг Улсын хуулийн дагуу тайлбарлаж зохицуулна.

S. Арбитр:

S.1 Энэхүү Хэлэлцээрээс үүдэн талуудын хооронд үүсэх аливаа маргааныг 1996 оны Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Арбитр болон эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны тухай хуулийн хүрээнд, түүний дагуу томилогдсон нэг буюу түүнээс дээш тооны арбитрчаар шийдвэрлүүлэх ба арбитраас гаргасан шийдвэрийг талууд заавал биелүүлнэ. Маргааны талаар арбитрын шүүхэд хандах гэж буй тал шүүхэд хандах өдрөөс 4-өөс доошгүй долоо хоногийн өмнө нөгөө талдаа энэ тухай бичгээр мэдэгдэнэ. Арбитрын хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах газар нь Энэтхэг Улсын Мумбай хот байх бөгөөд арбитрын үйл ажиллагааны хэл нь англи хэл байна.

S.2 Зээлийн хэлэлцээр болон түүний дагуу байгуулагдсан бусад баримт бичгээс үүдэх аливаа арбитрын хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах газар нь Мумбай хот байхыг Зээлдэгч үүгээр буюу цаашид эсэргүүцэхээс ямарваа нөхцөл болзолгүйгээр, бүрмөсөн татгалзана. Түүнчлэн Зээлдэгч арбитрын шүүхээс түүний эсрэг гаргасан шийдвэр нь үүссэн маргаан бүхий нөхцөл байдал болоод түүний төлж барагдуулбал зохих хохирлын хэмжээг тогтоосон нотолгоо болох бөгөөд тэрхүү шийдвэрийг түүний баталгаажсан үнэн зөв хуулбарыг үндэслэн Зээлдэгчийн улсын гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх тухай хууль тогтоомжийн дагуу Зээлдэгчийн улсад биелүүлж гүйцэтгэхийг зөвшөөрөв.

S.3 Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээр болон түүний дагуу байгуулсан бүх баримт бичигтэй холбоотойгоор үүссэн аливаа арбитрын ажиллагааны дүнд гарсан буюу гарч болох шийдвэртэй холбогдуулан зохих хохирлыг барагдуулах, эсхүл аливаа өмч хөрөнгө (түүний зориулалт, эсхүл дам зориулалтыг үл харгалзан)-тэй холбоотой аливаа шүүхийн буюу арбитрын шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, гүйцэтгэх зэрэг арга хэмжээ авахыг үүгээр зөвшөөрөв.

S.4 Зээлдэгч буюу түүний өмч, хөрөнгө, орлогын алин боловч шүүхэд дуудагдах, хураагдах /шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхээс өмнө буюу шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлж буй аль ч үед/, нөхөн төлөх, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх буюу эсхүл бүрэн эрхт байдлын буюу бусад



үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хамгаалагдах халдашгүй дархан байдал, онцгой эрх олгогдох, түүнчлэн аливаа эрх зүйн тогтолцооны дагуу Зээлдэгч, түүний хөрөнгө, орлогод халдашгүй, онцгой эрх олгогдсон тохиолдолд Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрээр хүлээсэн үүргийнхээ дагуу тухайн эрх зүйн тогтолцоо, түүний хууль тогтоомжоор зөвшөөрөгдөх хэмжээнд тэдгээр эрхээс бүрмөсөн татгалзахыг зөвшөөрөв.

Т. Мэдэгдэл:

Зээлийн хэлэлцээртэй холбогдуулан хийх аливаа мэдэгдэл, хүсэлт, шаардлагыг агаарын шуудан, цахилгаан, баталгаажуулсан СВИФТ КОД, эсхүл факсаар илгээхдээ зохих ёсоор хүргүүлэх буюу мэдээлнэ. Эдгээр мэдэгдэл, хүсэлт, шаардлагыг хүргүүлэхдээ хүлээн авагч талын дор заасан хаяг, эсхүл бичгээр мэдэгдсэн бусад хаягаар илгээсэн бол уг мэдэгдэл, хүсэлт, шаардлагыг зохих ёсоор хүргүүлсэн буюу мэдээлсэн гэж үзнэ. Хэрэв аливаа мэдэгдэл, хүсэлт, шаардлагыг цахилгаанаар, эсхүл факсаар илгээсэн бол илгээгч тал нь тэдгээрийн баталгаажуулсан хувийг шуудангаар зохих хугацааны дотор хүргүүлнэ.

ЗЭЭЛДЭГЧ:

Монгол Улсын Засгийн газар

Хариуцах байгууллага:

Сангийн яам
Засгийн газрын II байр
С.Данзаны гудамж 5/1
Утас: +976 51 264694
Факс: +976 51 267468

ЭКСИМ БАНК:

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-
Импортын Банк
Баракхамба зам, Стейтсмен Хаус 148,
Шинэ Дели 110 001

Хариуцах байгууллага:

“Эл Өү Си” Групп
Утас: (91-11) 23474800/ 23474851
Факс: (91-11) 23321719/ 23322758
Свифт код: EIBIINBB

ҮҮНИЙГ НОТЛОН, талуудыг төлөөлж эрх олгогдсон эрх бүхий этгээдүүд дор дурдсан өдөр энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав. Хэлэлцээрийг хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

Сангийн сайд Ч.Хүрэлбаатар
2019 оны 10 дугаар сарын 09-ний өдөр

БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛСЫН ЭКСПОРТ-ИМПОРТЫН БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ

Ерөнхий менежер Шри Сараож Кунтия
2019 оны 10 дугаар сарын 09-ний өдөр
Гарын үсэг зурав.

Хавсралт-1

Тендер, худалдан авах ажиллагааны журам

- a. Зээлдэгч урьдчилсан шаардлагууд болон тендерийн баримт бичгүүдийг тендер зарлахаас өмнө ЭКСИМ банк руу хүргүүлж, баталгаажуулна;
- b. Худалдан авах ажиллагааны баримт бичгүүдийг бүрэн хэмжээгээр бүрдүүлж өгөх шаардлагатай бөгөөд энэ нь ямарваа нэгэн байдлаар хязгаарлагдмал биш ба Энэтхэг Улсын компаниудыг өргөн хүрээгээр оролцуулсан байна. Төлбөрийн нөхцөлүүд нь Төслийн хүрэх зорилготой уялдсан байна. ЭКСИМ банк нь урьдчилсан төлбөрийг хэлэлцээрийн нийт дүнгийн 20%-тай тэнцэх хэмжээгээр хязгаарлаж болно. Хэлэлцээрийн 10%-тай тэнцэх хэмжээний санхүүжилтийг төслийн хүрээнд худалдан авах тоног, төхөөрөмжийг суурилуулж, хүлээлгэн өгснөөр олгоно. Хугацаа хоцорсон тохиолдолд хэлэлцээрийн дүнгийн 1-5%-тай тэнцүү хэмжээний мөнгөн төлбөрийн хохирлыг төлбөрийн нөхцөлд тусгана;
- c. ЭКСИМ банк Энэтхэг Улсын аж ахуйн нэгж, байгууллагуудад Сонирхлоо илэрхийлэхийг урьж, төсөл тус бүрээр урьдчилсан шалгаруулалт явуулна. Урьдчилсан шалгуур хангасан компани, аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг Зээлдэгчид хүргүүлнэ. Зээлдэгч урьдчилсан шалгуур хангасан компани, аж ахуйн нэгж, байгууллагыг тендер шалгаруулалтад оролцохыг урина;
- d. Зээлдэгч нь Эрх бүхий гэрээг байгуулж хэрэгжүүлэх Энэтхэгийн талын Худалдагчийг сонгохдоо өрсөлдөөнт тендер шалгаруулалтыг нээлттэй, шударга явуулах үүднээс Зээлдэгчийн улсад хүчин төгөлдөр үйлчилж буй худалдан авах ажиллагааны хууль тогтоомж, дүрэм журмыг баримтлан зохион байгуулж болох бөгөөд Зээлдэгчийн улсын өрсөлдөөнт тендер шалгаруулалттай холбоотой



- дүрэм, журмыг нарийвчлан тайлбарлаж, ЭКСИМ банкинд урьдчилан хүргүүлсэн байна;
- e. Хэрэв аливаа байгууллага Энэтхэг эсвэл Зээлдэгчийн улсын хар жагсаалтад бүртгэлтэй бол урьдчилсан шалгаруулалт болон сонгон шалгаруулалтад оролцох эрхгүй байна;
 - f. Зээлдэгч тендерийн үнийг зөвхөн ам.доллараар илэрхийлнэ;
 - g. Зээлдэгч ТНТ болон тендерийн баримт бичигтэй уялдуулж төслийн ажил, үнэ болон төлбөрийн хуваарийг боловсруулж болно. ТНТ-д тусгасан ерөнхий зардал гарчигийн дор зардлуудыг илүү дэлгэрэнгүй дэд гарчгаар оруулна. Гэрээ, ТНТ болон тендерийн баримт бичиг хооронд аливаа зөрүү гарсан тохиолдолд эдгээр зөрүүг баталгаажуулах дэлгэрэнгүй тайлбарыг гаргасан байна;
 - h. ЭКСИМ банк гэрээний төсөл нь тендерийн баримт бичиг болон ТНТ-д нийцэж байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийнэ. Зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд Зээлдэгчийн улсын тайлбарыг авсны дараа Энэтхэг Улсын Засгийн газар нийцүүлэх арга хэмжээг авна. Шаардлагатай тохиолдолд ЭКСИМ банк гэрээний төслийг боловсруулах талаар саналаа Зээлдэгчид хүргүүлж болно;
 - i. Зээлдэгч Сонгон шалгаруулалт хийгдсэний дараагаар гэрээний төслийг тендерийн үнэлгээний тайлангийн хамт боловсруулан ЭКСИМ банкинд хүргүүлнэ. ЭКСИМ банк нь Зээлдэгч гэрээ байгуулах эрхийг ил тод байдал, шударга өрсөлдөөнөөр олгосон гэдгийг баталгаажуулах зорилгоор дээрх баримт бичгүүдийг хянан шалгаж, гэрээг Зээлийн хүрээнд оруулах талаарх мэдэгдлийг Зээлдэгчид хүргүүлнэ;
 - j. Тендер шалгаруулалтын журамд гарсан аливаа зөрүү, өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй тайлбарыг Зээлдэгч ЭКСИМ банкинд хүргүүлэх бөгөөд ЭКСИМ банк тухайн гэрээг баталгаажуулах талаар Энэтхэг Улсын Засгийн газрын шийдвэр гаргуулна;
 - k. Зээлдэгч нь гэрээ байгуулах эрхийг үнэлгээний ил тод, тэгш шалгуур, журмын дагуу олгох ба ЭКСИМ банк ил тод байдал, шударга өрсөлдөөний хэм хэмжээг зөрчсөн аливаа гэрээг цуцлах эрхтэй болно;
 - l. Гэрээг Зээлдэгч/түүнийг төлөөлөх эрх бүхий агентлаг/Худалдан авагч/Хэрэгжүүлэгч байгууллага болон Зээлдэгчийн эрхийн дагуу сонгогдсон Энэтхэг Улсын нийлүүлэгч, эсхүл гэрээлэгчийн хооронд байгуулна. ЭКСИМ банк нь сонгон шалгаруулалттай холбоотой үүрэг хүлээхгүй болно. Зээлдэгч нь төслийг хэрэгжүүлэх болон Төслийн хүрээнд гэрээ байгуулах эрх олгох, түүнийг зохицуулах үүрэг хүлээнэ.



Хавсралт-II

ГЭРЭЭ БАТЛАХ МАЯГТ

(Монгол Улсын Засгийн газрын хэвлэмэл хуудас дээр үйлдэнэ)

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЭКСИМ БАНК ХООРОНД
2016 ОНЫ 4 САРЫН 28-НЫ ӨДӨР БАЙГУУЛСАН ЗЭЭЛИЙН
ХЭЛЭЛЦЭЭРИЙН ДАГУУ
САНХҮҮЖҮҮЛЭХ ЭКСПОРТЫН ГЭРЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА.**

1. Гэрээний №, огноо :
2. Импортлогчийн нэр, хаяг :
3. Экспортлогчийн нэр, хаяг :
4. Гэрээний мөнгөн тэмдэгт : ам.доллар
5. Гэрээний үнэ : FOB/CFR/CIF/CIP
 - (i) FOB:
 - (ii) Тээвэрлэлт:
 - (iii) Даатгал
 - (iv) Нийт CFR/CIF:
6. (a) Хойшлуулсан зээл (100%) :
- (b) Зээлийг хойшлуулсан хугацаа :
7. Барааны тодорхойлолт:
8. Бараа нийлүүлэлтийн хугацаа:
9. Тээвэрлэлтийн өмнөх шалгалт хийх байгууллага:
10. Зээлийг төлөхөд шаардагдах хугацаа :

(Эрх бүхий этгээд(үүд)-ийн нэр, гарын үсэг)

Хавсралт-III

ТӨЛБӨРИЙН ЗӨВШӨӨРЛИЙН МАЯГТ

(Монгол Улсын Засгийн газрын хэвлэмэл хуудас дээр үйлдэнэ)

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын Банк
Хаяг
Эрхэм хүндэт Ноёдоо,

_____ -ний өдөр гарын үсэг зурсан 1 тэрбум ам.долларын Зээл олгох тухай Зээлийн хэлэлцээрийн хүрээнд _____ (Худалдагч) болон



_____ (Худалдан авагч) нарын хооронд байгуулсан _____ ам.долларын өртөг бүхий гэрээний тухай

Худалдан авагчийн зохих ёсоор баталгаажуулсан *дээрх гэрээний дагуу урьдчилгаа төлөхтэй/*дээрх гэрээний дагуу Худалдагчаас Худалдан авагчид үзүүлсэн үйлчилгээтэй холбоотой _____ ам.долларын _____ нэхэмжлэхийг Худалдагчаас бидэнд ирүүлснийг мэдээлж байна.

Иймд бид нэхэмжлэхэд дурдсанам.долларыг Худалдагчийн заасан дансанд Худалдагчаас ЭКСИМ банкинд өгсөн төлбөрийн зааврын дагуу төлөх эрхийг ЭКСИМ банкинд бүрнээ олгож байна. ЭКСИМ банкнаас Худалдагчид төлсөн мөнхүү дүнг Зээлийн хөрөнгөөс бидэнд олгож буй Урьдчилгаа хэмээн тооцох бөгөөд ЭКСИМ банкнаас уг төлбөрийг хийсэн/ Мумбайгаас уг төлбөрийг шилжүүлсэн огноог Урьдчилгаа хийсэн огноо хэмээн тооцно.

Дээр дурдсаны дагуу урьдчилгааг төлсөн даруйдаа төлбөр хийсэн огноо, төлбөрийн дүнгийн талаар бидэнд мэдэгдэхийг ЭКСИМ банкнаас хүсье.

Хүндэтгэсэн,

* Тохирохгүй хэсгүүдийг хасна уу.

(Эрх бүхий этгээд(үүд)-ийн нэр, гарын үсэг)

Хавсралт баримт бичиг-1

**ЗЭЭЛДЭГЧИЙН ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГЫН
ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТИЙН ЗАГВАР**

(Монгол улсын Засгийн газрын Хуулийн байгууллагын хэвлэмэл хуудас дээр үйлдэнэ)

Дугаар:

Огноо:

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын Банк
Нэгдүгээр төв барилга, 21 дүгээр давхар
Дэлхийн Худалдааны Төвийн цогцолбор
Кафф Парэйд Мумбай-400 005

Монгол улсын Засгийн газарт олгох,-нд
байгуулсан 1 тэрбум ам.долларын зээлийн тухай

1. _____ Засгийн газар /“Засгийн газар”/-ын яамны Хуулийн зөвлөх /Нэр/ миний бие-ын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын Банк /“ЭКСИМ Банк”/-ны хооронд ...ны өдөр байгуулсан, ЭКСИМ Банкаас-ын Засгийн газартам.долларын өртөг бүхий зээл /“Зээл”/ олгох тухай Зээлийн хэлэлцээрийн хуулбартай танилцлаа.

Үүнтэй холбогдуулан миний бие Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомж, тогтоол, шүүхийн шийдвэрүүд, дүрэм журмууд болон дор дурдсан хууль зүйн дүгнэлтийг гаргахад чухал шаардлагатай буюу хамааралтай хэмээн үзсэн гэрээ, хэлэлцээр, баримт бичгүүдийг судлан үзэв.

Дээр дурдсаны дагуу миний бие дараахь дүгнэлтийг хийв. Үүнд:

- (а) Засгийн газар нь Хэлэлцээрийг байгуулах, Хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх бүрэн эрх хэмжээтэй байна;
- (б) Монгол Улсын Засгийн газрын _____ яамыг төлөөлж Засгийн газрын нэрийн өмнөөс Хэлэлцээрт гарын үсэг зурсан ноён _____ болон ноён _____ нь (нар нь) Хэлэлцээр болон түүнтэй холбоотой бүх баримт бичгийг Засгийн газрын нэрийн өмнөөс байгуулах бүрэн эрх олгогдсон эрх бүхий этгээд(үүд) байна;
- (с) Гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, бусад журмыг Засгийн газрын зохих эрх бүхий хүмүүс / аж ахуйн нэгжүүд хийж гүйцэтгэв.
- (д) Гэрээг Засгийн газрын нэрийн өмнөөс хийж, гарын үсэг зурж, хүлээлгэн өгч, Засгийн газар түүний бүхий л нөхцөл, нөхцөлийг харгалзан хүчин төгөлдөр байлгах бөгөөд заавал биелүүлэх үүрэг болно.

Энэхүү дүгнэлтийг Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой холбогдох Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд гаргасан бөгөөд өөр бусад хуулийн харьяалал, түүний хууль тогтоомжийн талаар дүгнэлт тайлбар хийгээгүй болно.

Хүндэтгэсэн,

(Хуулийн зөвлөхийн нэр, гарын үсэг)



Хавсралт баримт бичиг-II

ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ЭРХ ОЛГОХ МАЯГТЫН ЗАГВАР

(Монгол Улсын Засгийн газрын хэвлэмэл хуудас дээр үйлдэнэ)

Дугаар:

Огноо:

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын Банк
Нэгдүгээр төв барилга, 21 дүгээр давхар
Дэлхийн Худалдааны Төвийн цогцолбор
Кафф Парэйд Мумбай-400 005

Re: Эксим банкнаас Монгол улсын Засгийн газарт олгох,-нд
байгуулсан 1 тэрбум ам.долларын зээлийн хэлэлцээр

_____ овогтой _____ миний бие (албан тушаал)
_____ (“Зээлдэгч”) дараахь албан тушаалтнуудад хамтран/
хэсэгчлэн* Төлбөр хийх зөвшөөрөл олгох болон бусад баримт бичигт
гарын үсэг зурах, Хэлэлцээрийн хэрэгжилттэй холбоотойгоор Зээлдэгчийг
төлөөлөх эрхийг олгож байгааг үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

Нэр	Албан тушаал	Баталгаат гарын үсэг

*Тохиромжгүй хэсгүүдийг хасна уу:

Тамга (Эрх бүхий этгээд(үүд)-ийн нэр, гарын үсэг)

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 4,5

Индекс: 200003